



АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ УНДСЭН ТАЙЛАН 2010

МОНГОЛ
УЛСЫН
УНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

Улаанбаатар хот
2011 он



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН 2010

Улаанбаатар хот
2011 он



Хаяг: Засгийн газрын III байр,
Улаанбаатар- 20 а, Монгол Улс
Утас: 322424, 326414, 261523
Факс: (976 -11) - 324518
Цахим хаяг: nso@magicnet.mn,
information@nso.mn
Веб хаяг: <http://www.nso.mn>



Гарчиг

.....

Хүснэгт зургийн жагсаалт.....	VI
Өмнөх үг.....	XI
Бүлэг 1. Судалгааны арга зүй, зохион байгуулалт,	
оилголт тодорхойлолтууд	3
1.1 Нийтлэг зүйл	3
1.2 Судалгааны зорилго	4
1.3 Тайлангийн агуулга, бүтэц	4
1.4 Судалгааны хамрах хүрээ	5
1.5 Судалгааны түүвэрлэлт	5
1.6 Судалгааны асуулгын хуудас, мэдээлэл цуглувалт	7
1.7. Мэдээлэл боловсруулалт.....	8
1.8 Ойлголт тодорхойлолтууд.....	9
Бүлэг 2. Хүн ам зүйн болон өрхийн үзүүлэлтүүд	17
2.1 Нийтлэг зүйл	17
2.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд	17
2.3 Хүн амын тоо, байршил, бүс нутгаар	17
2.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц	19
2.5 Хүн ам зүйн ачаалал	21
2.6 Гэрлэлтийн байдал.....	21
2.7 Өрхийн бүтэц.....	22
2.8 Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх	23
2.9 Боловсролын түвшин	24
2.10 Бичиг үсгийн мэдлэгийн түвшин	25
Бүлэг 3. Ажиллах хүч	29
3.1 Танилцуулга	29
3.2 Ажиллах хүчний оролцооны түвшин.....	29
3.3 Насны бүлэг дэх оролцооны түвшин.....	33
3.4 Эдийн засгийн идэвхгүй хүн ам	35

Бүлэг 4. Хөдөлмөр эрхлэлт	41
4.1 Тухайн үеийн ажиллагчид	41
4.2 Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	43
4.3 Ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар	46
4.4 Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар	47
4.5 Ажиллагчдын тоо, байгууллагын хариуцлагын хэлбэрээр	48
4.6 Давхар хөдөлмөр эрхлэлт	49
4.7 Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт	50
Бүлэг 5. Ажилгүйдэл	59
5.1 Нийтлэг зүйл	59
5.2 Ажилгүй иргэдийн тоо	59
5.3 Ажилгүйдлийн түвшин	61
5.4 Ажилгүй иргэдийн боловсролын түвшин	62
5.5 Ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан	65
Бүлэг 6. Албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлт	69
6.1 Нийтлэг зүйл	69
6.2 Тодорхойлолт	69
6.3 ХАА-н салбарын хөдөлмөр эрхлэлт	70
6.4 ХАА болон ХАА-н бус салбар дахь хөдөлмөр эрхлэлт	70
6.5 Албан бус сектор дахь аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо	72
6.6 Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	74
6.7 Албан бус сектор дахь ажиллагчдын тоо ажил мэргэжлийн ангиллаар	76

Бүлэг 7. Ажиллах хүчний улирлын хэлбэлзэл	79
7.1 Нийтлэг зүйл	79
7.2 Эдийн засгийн идэвхтэй хүн ам	79
7.3 Ажиллагчдын тоо	80
7.4 Ажилгүй иргэдийн тоо	83
Бүлэг 8. Ажиллах хүчний 2007-2008, 2008-2009, 2009, 2010 оны судалгааны үндсэн үр дүнгийн харьцуулалт	87
8.1 Нийтлэг зүйл.....	87
8.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд.....	87
8.3 Эдийн засгийн идэвхтэй хүн ам	89
8.4 Ажиллагчдын тоо	91
8.5 Ажилгүй иргэдийн тоо	94
Бүлэг 9. Түүврийн алдаа	97
9.1 Нийтлэг зүйл	97
9.2 Түүвэрлэлт	97
9.3 Түүврийн алдаа	101

Хүснэгт, зургийн жагсаалт

.....

Хүснэгт 1.1 Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэг тус бүр,	6
сонгогдсон ТАШН, өрхийн тоо	
Хүснэгт 2.1 Өрх, хүн амын тоо, хот хөдөө, бүсээр	18
Хүснэгт 2.2 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөөгөөр, бүсээр	18
Хүснэгт 2.3 Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр, хүйсээр	19
Хүснэгт 2.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа	20
Хүснэгт 2.5 Хүн ам зүйн ачаалал хот, хөдөө, бүсээр	21
Хүснэгт 2.6 Хүн амын гэрлэлтийн байдал хот, хөдөө, бүсээр,%.....	22
Хүснэгт 2.7 Өрхийн тоо, ам бүлийн тоогоор, байршилаар, бүсээр,%.....	23
Хүснэгт 2.8 Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор, хот хөдөөгөөр	23
Хүснэгт 2.9 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо боловсролын түвшингээр, хүйсээр, хот, хөдөөгөөр,%.....	24
Хүснэгт 2.10 Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлгадалтын түвшин, хот, хөдөө, бүсээр, хүйсээр,.....	25
Хүснэгт 2.11 Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлгадалтын түвшин, насны бүлгээр, хот, хөдөөгөөр, хүйсээр	25
Хүснэгт 3.1 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хот, хөдөөгөөр, хүйсээр	30
Хүснэгт 3.2 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлын зэрэгцүүлэлт, судалгаануудын дүнгээр.....	31
Хүснэгт 3.3 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин тухайн насны бүлгээр, хот, хөдөө, хүйсээр.....	33
Хүснэгт 3.4 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам, идэвхгүй байгаа шалтгаан, дүнд эзлэх хувиар, хүйс, байршилаар.....	36

Хүснэгт 4.1 Ажиллагчид, хүйсээр, хот, хөдөө, бүсээр.....	41
Хүснэгт 4.2 Ажиллагчид, хүйс, аймаг, нийслэлээр.....	42
Хүснэгт 4.3 Ажиллагчид, хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	43
Хүснэгт 4.4 Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, дүнд эзлэх хувиар	46
Хүснэгт 4.5 Тухайн үед хөдөлмөр эрхэлсэн 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, хот, хөдөө, бүс нутгаар	48
Хүснэгт 4.6 Сүүлийн 7 хоногт давхар хөдөлмөр эрхэлсэн хүн амын тоо, хүйс, ажил мэргэжлийн ангиллаар	49
Хүснэгт 4.7 Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой хүний тоо, хүйсээр, хот, хөдөө, бүсээр	51
Хүснэгт 4.8 Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой хүний тоо, ажил хайсан хэлбэрээр, байршилаар	53
Хүснэгт 4.9 Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой хүн амын тоо, хугацаа, хот, хөдөө, бүсээр	54
Хүснэгт 5.1 Ажилгүй иргэдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хүйс, хот, хөдөө, бүс нутгаар.....	60
Хүснэгт 5.2 Ажилгүй иргэдийн насны бүтэц, хувиар.....	61
Хүснэгт 5.3 Ажилгүй иргэдийн боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар	63
Хүснэгт 6.1 ХАА болон ХАА-н бус салбарт тухайн үед ажилласан, 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, хүйсээр, хот, хөдөө, бүсээр	71
Хүснэгт 6.2 Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, хүйс, хот, хөдөө, бүсээр	72
Хүснэгт 6.3 Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, аймаг, нийслэл, хүйсээр	73
Хүснэгт 6.4 Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр.....	74
Хүснэгт 6.5 Албан бус секторт дахь ажиллагчдын тоо, хүйсээр, ажил мэргэжлийн ангиллаар	76

Хүснэгт 7.1 15 ба түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх, улирлын тооцоогоор	79
Хүснэгт 7.2 15 ба түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлсэн хүн амын тоо, хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, улирлаар.....	81
Хүснэгт 7.3 15 ба түүнээс дээш насны ажилгүй иргэдийн тоо, хүйсээр, байршилаар, улирлаар.....	84
Хүснэгт 8.1 Өрх, хүн амын тоо, АХС-ны дүнгээр.....	88
Хүснэгт 8.2 15 ба түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх, АХС-ны дүнгээр.....	90
Хүснэгт 8.3 15 ба түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлсэн хүн амын тоо, 2007-2008, 2008-2009, 2009, 2010 оны АХС-ны дүнгээр	92
Зураг 2.1 Хүн амын насны бүтэц, АХС-ны дүнгээр	20
Зураг 3.1 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр байршилаар	32
Зураг 3.2 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр.....	34
Зураг 3.3 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр	34
Зураг 3.4 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амын бүтэц, шалтгаанаар	37
Зураг 4.1 Ажиллагчдын тоо, хүйс, хот, хөдөөгөөр	42
Зураг 4.2 Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилаар, хувиар	45
Зураг 4.3 Ажиллагчид хөдөлмөр эрхлэлтийн статусаар, хувиар	47
Зураг 4.4 Сүүлийн 7 хоногт давхар хөдөлмөр эрхэлсэн хүн амын бүтэц, давхар хөдөлмөр эрхэлсэн хугацаагаар, хувиар	50
Зураг 4.5 Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой ч эрхлээгүй шалтгаан, улсын дүнгээр, хувиар.....	52
Зураг 4.6 15 ба түүнээс дээш насны нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан хүний тоо, хүйс, хот, хөдөө, бүсээр	55
Зураг 4.7 15 ба түүнээс дээш насны, нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан хүн, шалтгаанаар, хувиар.....	56
Зураг 5.1 Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр.....	62
Зураг 5.2 Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, боловсролын түвшингээр, хувиар	63

Зураг 5.3 Ажилгүйдлийн түвшин, аймаг, нийслэлээр, хувиар.....	64
Зураг 5.4 Ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлээгүй шалтгаанаар, хувиар.....	65
Зураг 6.1 Албан бус сектор дахь ажиллагчид, хот, хөдөө, бүсээр, хувиар	72
Зураг 6.2 Албан бус секторт ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	75
Зураг 7.1 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, улирлаар.....	80
Зураг 7.2 Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбарууд, улирлаар.....	82
Зураг 7.3 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хот, хөдөөгөөр, улирлаар.....	82
Зураг 7.4 Ажилгүйдлийн түвшин, улирлаар, хувиар	83
Зураг 8.1 Хүн амын насны бүтэц, 2000 оны ХАОСТ, 2002-2003, 2006-2007, 2007-2008, 2008-2009, 2009, 2010 оны АХС-ны дүнгээр.....	89
Зураг 8.2 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, АХС-ны дүнгээр.....	91
Зураг 8.3 Ажиллагчдын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын бүтэц, 2007-2008, 2008-2009, 2009, 2010 оны АХС-ны дүнгээр	93
Зураг 8.4 Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдлын бүтэц, 2009, 2010 оны судалгааны дүнгээр	93
Зураг 8.5 Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, ажиллах хүчний судалгааны дүнгээр, хувиар	94

2010

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн хариулцаанд шилжсэн он жилүүдэд хүн амын амьжиргааны түвшин, ажил эрхлэлт, амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт орж богино хугацаанд хувьсан өөрчлөгдөж байгааг дагалдан ажиллах хүч, ажил эрхлэлт, ажилгүйдлийн талаарх бодит мэдээллийн хэрэгцээ байнга өсөн нэмэгдэж байна.

Ажиллах хүчиний түүвэр судалгаа (АХС) нь Монгол Улсын хувьд хүн амын ажил эрхлэлтийн талаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүн амын эдийн засгийн идэвхийг 2 арга/”тухайн үеийн” болон “байнгын” гэсэн/-аар тооцсон ажил эрхлэлтийн талаарх анхны томоохон түүвэр судалгаа юм. Энэхүү судалгаа нь хамрах хүрээ, багтаамж, агуулгаараа ч, тоо мэдээлэл нь бүтэн нэг жилийг хамарч улирлын нөлөөллийг бүрэн тусгасан жилийн дүнг гаргаж байгаагаараа ч, олон улсын аргачлалын дагуу хийснээрээ ч төр засаг, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач наарт байнгын хэрэглэгдэхүүн болсон ач холбогдол бүхий судалгаа юм.

Ажиллах хүчиний түүвэр судалгаа нь хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжүүд болон ажилгүй иргэдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгч байгаагаараа нийгэм, иргэдийн амьдралд тулгарч байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд нэн ач холбогдол бүхий суурь, бодит мэдээллийн шинэ эх үүсвэрүүдийг илрүүлснээрээ ихээхэн ач холбогдолтой. Энэ нь зөвхөн шилжилтийн үеийн нэг хэсэг бэрхшээлийг шийдэх төдий бус үлс орны хөгжлийн тулгуур асуудлыг шийдэх, цаашдын бодлогыг тодорхойлоход ч үндсэн мэдээлэл болно. Мөн АХС-ны мэдээлэл цуглуулах явцад албан бус секторын ажил эрхлэлтийн шинж төлөв, хандлагыг тодорхойлох зорилго тавьсан нь нүүдлийн болон суурин амьдралын хосолмол хэв шинжтэй манай орны хувьд сонирхол татахуйц, тэр бүр анхаарал төвлөрөхгүй явж ирсэн зарим асуудлын үр дагаварыг гүнзгийрүүлэн судлах боломжийг нээж өгч байгаа юм.

ҮСХ нь “Ажиллах хүчиний түүвэр судалгаа (АХС)”-г олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу 2006 оноос эхлэн улирлаар явуулж байгаа нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болж байна.

Монгол Улсын Засгийн газраас “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” жилийг зарлан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад нэн тэргүүний ач холбогдол өгч буй энэ үед АХС-ны үр дүн ихээхэн чухал ач холбогдолтой байх нь дамжиггүй юм. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөх, ядуурлын дүн шинжилгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн үр дүнг дүгнэх, үнэлгээ өгөхөд шаардлагатай олон чухал тоо мэдээллийг энэхүү тайланда багтаасан бөгөөд эдгээр мэдээлэл нь хэрэглэгч олон түмний эрэлт, хэрэгцээнд нийцнэ хэмээн найдаж байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

С.МЭНДСАЙХАН

БҮЛЭГ I

**СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТУУД**

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТУУД

1.1. Нийтлэг зүйл

Монгол Улсад “Ажиллах хүчний судалгаа(АХС)”—г 2002-2003 онд анх удаа олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Харин олон улсын нийтлэг аргачлалын дагуу АХС-г улирлаар тогтмол явуулж байх нь зүйтэй гэж үзэн 2004 онд Монгол Улсын “Статистикийн тухай” хуулинд нэмэлт заалт оруулсны дагуу 2006 оноос эхлэн АХС-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн тархааж байгаа билээ. Энэ хугацаанд АХС-тай хавсарга болгон Хүүхдийн хөдөлмөрийн судалгааг хоёр удаа, Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааг нэг удаа явуулж, судалгааны үр дүнгийн тайланг тусгайлан боловсруулан гаргаж тархаасан. АХС нь олон улсад мөрдөж буй нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачалаар тооцох замаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн статусыг тодорхойлон, хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд, бүс нутаг, хот, хөдөө, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, хөдөлмөр эрхлэлтийн статусаар улирлын нөлөөллийг тусган тооцож гаргаснаараа чухал ач холбогдолтой юм.

Ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлт байсаар байгаа өнөөгийн нөхцөлд хөдөлмөр эрхлэлтийн стратеги, хөтөлбөрийг боловсруулах, үр дүнг дүгнэхэд шаардлагатай статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой зөв тооцох, мэдээллийн давтамжийг тогтмолжуулах, хөдөлмөрийн статистикийн системийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргах, судалгаа явуулах болон холбогдох үндсэн үзүүлэлтүүдийн талаархи ойлголт, тодорхойлолт, тэдгээрийг тооцох аргачлал 2009 оны 6 дугаар сард шинэчлэн батлагдсан билээ. Иймд 2009 оны 7 дугаар сараас эхлэн явагдсан АХС-ны асуулга, зааврыг шинэчлэн батлагдсан ойлголт, тодорхойлолтын дагуу холбогдох өөрчлөлтүүдийг тусган боловсруулсан.

Монгол Улсад албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлт нь орлогын нэлээд хэсгийг бүрдүүлдэг. Иймд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын зөвлөмжийн дагуу албан бус секторын талаарх тоо мэдээг тогтмол цуглуулж байна. Үүний үр дүнд албан бус секторын цар хүрээ, хэмжээ, төлөв байдлын талаар байнгын мэдээлэлтэй болж, гарч буй өөрчлөлтөнд хяналт тавих боломжтой болж байгаа юм.

1.2. Судалгааны зорилго

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулах” заалтыг хэрэгжүүлж хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан дүн шинжилгээ хийж, түүнийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, бизнес эрхлэгчид, шинжлэн судлаачид, төр захиргааны албаны ажилтан хэн бүхэнд хөдөлмөрийн зах зээлийг зөв төлөвшүүлэн хөгжүүлэхэд ашиглах гарын авлага, тогтмол мэдээллийн эх сурвалжийг бий болгоход оршино. Үүний тулд ОУХБ-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн холбогдолтой үзүүлэлтүүдийг улирлын нөлөөллийг тусган бүс нутаг, байршил, аймаг, нийслэл, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар өргөн хэмжээнд тооцож гаргахад шаардлагатай иж бүрэн тоон мэдээллийг өрхүүдээс цуглуулах зорилт тавьж ажиллаа.

1.3. Тайлангийн агуулга, бүтэц

Ажиллах хүчний энэ удаагийн судалгааны үр дүнгийн тайлан нь дараах 9 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

Бүлэг 1. Судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт, тодорхойлолтууд

Бүлэг 2. Хүн ам зүйн болон өрхийн үзүүлэлтүүд

Бүлэг 3. Ажиллах хүч

Бүлэг 4. Хөдөлмөр эрхлэлт

Бүлэг 5. Ажилгүйдэл

Бүлэг 6. Албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлт

Бүлэг 7. Ажиллах хүчний улирлын хэлбэрэлзэл

Бүлэг 8. Ажиллах хүчний 2007-2008, 2008-2009, 2009, 2010 оны

судалгааны үндсэн үр дүнгийн харьцуулалт

Бүлэг 9. Түүврийн алдаа

Тайлангийн 1-р бүлэгт судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт, тодорхойлолтууд, 2-р бүлэгт хүн ам зүйн үзүүлэлтүүд, 3-р бүлэгт ажиллах хүч, ажиллах хүчний тооцоо, ажиллах хүчний оролцооны түвшин, эдийн засгийн идэвхгүй байгаа шалтгааны талаар, 4-р бүлэгт тухайн үед хөдөлмөр эрхэлж буй 15 ба түүнээс дээш насны хүн амын талаар, 5-р бүлэгт ажилгүйдлийн түвшин, залуучуудын дундах ажилгүйдлийн талаар, 6-р бүлэгт хөдөлмөр эрхэлж буй 15 ба түүнээс дээш насны хүн амын албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлтийн талаар,

7-р бүлэгт ажиллах хүчний байдлыг улирлаар харьцуулан харуулсан бол 8-р бүлэгт сүүлийн 4 удаагийн буюу 2007-2008, 2008-2009, 2009, 2010 онд явуулсан судалгааны үндсэн үр дүнгийн харьцуулалтын талаар тайлбарласан болно.

1.4. Судалгааны хамрах хүрээ

Ажиллах хүчний судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодит тоон мэдээллийг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймгийн түвшинд тооцож, тодорхойлно. Үүний тулд судалгааг байршилын хувьд Монгол Улсыг бүхэлд нь хамруулан өргөн цар хүрээнд явуулахаар төлөвлөж улсын хэмжээнд 4 бүс нутаг (Төв, Баруун, Зүүн, Хангай), Улаанбаатар хотын нийт 12816 өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдээс асуулга авахад хангалттай гэж үзэв. Судалгаа явуулсан нэг жилийн хугацаанд 12816 өрхийг бүрэн хамруулав.

Мэдээллийг сар бүр цуглуулан, үр дүнг улирлаар нэгтгэж, түүвэрлэгдсэн нийт өрхийн дөрөвний нэгийг тухайн улирлын судалгаанд хамруулсан болно.

Судалгаа нь өрхөд суурilan явагдаж байгаа тул цэргийн анги, дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, сүм хийд зэрэг нийтийн байруудад түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүмүүсийг хамруулаагүй болно. Учир нь нийтийн байрууд нь байнгын оршин суух газарт тооцогдохгүйгээс гадна байнгын орон гэргүй хүн амыг тодруулан судалгаанд хамруулахад бэрхшээлтэй байгаа юм.

1.5. Судалгааны түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийн нэгж нь өрх бөгөөд байнга хамтран амьдарч, орлогоо нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол илдэг нэг буюу хэд хэдэн хүнийг “өрх” гэж үзнэ. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг оруулаагүй болно.

Хүснэгт 1.1. Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэг тус бүрээр, сонгогдсон түүврийн анхан шатны нэгж (ТАШН), өрхийн тоо

Бүлгийн дугаар	Аймгийн нэр	Нийт хүн ам	Түүврийн нэгжийн тоо	Судалгаанд хамрагдсан өрхийн тоо	Улиралд судалгаанд хамрагдсан өрхийн тоо	Сард судалгаанд хамрагдсан өрхийн тоо
1	Архангай	85893	36	432	108	36
2	Баян-Өлгий	93017	36	432	108	36
3	Баянхонгор	80857	36	432	108	36
4	Булган	58834	24	288	72	24
5	Говь-Алтай	55426	24	288	72	24
6	Дорноговь	58295	24	288	72	24
7	Дорнод	73893	32	384	96	32
8	Дундговь	47622	20	240	60	20
9	Завхан	74906	32	384	96	32
10	Өвөрхангай	111977	40	480	120	40
11	Өмнөговь	50995	20	240	60	20
12	Сүхбаатар	54442	24	288	72	24
13	Сэлэнгэ	100202	36	432	108	36
14	Төв	87210	32	384	96	32
15	Үвс	77550	32	384	96	32
16	Ховд	82628	36	432	108	36
17	Хөвсгөл	125274	48	576	144	48
18	Хэнтий	70179	24	288	72	24
19	Дархан-Уул	91358	36	432	108	36
20	Орхон	91212	36	432	108	36
21	Говь-Сүмбэр	14135	8	96	24	8
Аймгийн дүн		1585905	636	7632	1908	636
Улаанбаатар						
22	Сонгино хайрхан	241416	96	1152	288	96
23	Баян зүрх	254086	96	1152	288	96
24	Баянгол	174851	72	864	216	72
25	Сүхбаатар	135103	48	576	144	48
26	Хан Үул	104394	36	432	108	36
27	Чингэлтэй	141243	60	720	180	60
28	Налайх	30215	12	144	36	12
29	Багануур Багахангай	29722	12	144	36	12
Улаанбаатарын дүн		1111030	432	5184	1296	432
НИЙТ ДҮН		2696935	1068	12816	3204	1068

Ажиллах хүчний болон Хүүхдийн хөдөлмөрийн 2002-2003 оны судалгааны түүвэрлэлтийн нэгж нь 2000 оны Хүн ам, орон сууцны улсын тооллогын нэгж байсан бол дараа дараагийн судалгаанд түүвэрлэлтийн нэгжээр Монгол Улсын засаг, захиргааны нэгжийг авч, тухайн судалгааны өмнөх оны хүн ам, өрхийн тоонд тухайлбал, энэ судалгааны хувьд түүвэрлэлтийг 2009 оны өрх, хүн амын тоонд үндэслэн хийсэн. Судалгаанд 21 аймаг тус бүрийг нэг бүлэг, Улаанбаатар хотын 9 дүүргийг 8 бүлэгт (хамгийн цөөн өрхтэй 2 дүүргийг нэг бүлэгт хамруулсан) хувааж нийт 29 бүлэг болгон хамруулсан. Судалгааны ТАШН нь Улаанбаатар хотын хувьд хорооны хэсэг, харин аймгийн хувьд багууд болно. Энэ түүвэр судалгаанд Улаанбаатар хотоос түүврийн анхан шатны 432 хэсэг, аймгаас 636 баг нийт 1068 нэгжийг, тухайн нэгж тус бүрээс 12 өрхийг сонгон судалгаанд хамруулснаар үр дүнг аймгийн түвшинд тооцох боломжтой болж байгаа юм.

Ажиллах хүчний түүвэр судалгаанд олон шатат түүврийн арга хэрэглэсэн. Түүвэрлэлтийг хийхдээ нийт хүн амд таамаглаж байгаа ажилгүй иргэдийн тооны эзлэх хувийн жингээр магадлал хийн тооцсон болно. Нөгөөтэйгүүр түүвэрлэлтийг аймаг, хотын дүүргээр бүлэглэн хуваарилахдаа нийт хүн амд пропорциональ харьцаагаар жигд тархаан тооцсон.

Түүврийн эхний шатанд “Пропорциональ магадлалт түүврийн арга”-ыг (ПМТА) ашиглан ТАШН-ийг Засаг захиргааны нэгжийн нийт хэмжээнд пропорционалиар сонгосон. Түүврийн хоёрдугаар шатанд ТАШН бүрээс 12 өрхийг сонгоходоо ТАШН-ээс энгийн санамсаргүй системчилсэн циклт түүврийн дэд түүвэрлэлтийн техникийг ашигласан болно. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдах өрхийг сонгоходоо 2 шаттай түүвэрлэлтийн (sub-sampling) аргыг хэрэглэсэн.

1.6. Судалгааны асуултын хуудас, мэдээлэл цуглуулалт

Ажиллах хүчний судалгааны 2006-2007 оны асуулга 7 бүлэг бүхий 149 асуултаас бүрдэж байсан бол энэ удаагийн судалгаа нь 6 бүлэг 139 асуултаас бүрдэж байгаа нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой нарийвчилсан үзүүлэлтүүдийг хассантай холбоотой.

Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан, эдийн засгийн тухайн үеийн болон байнгын идэвхийн тодорхойлолт, тооцох аргачлалыг ашиглан судалгааны асуулгыг дараах мэдээллийг боловсруулан гаргахад чиглүүлж боловсруулсан. Үүнд:

- Хүн ам зүйн үзүүлэлтүүд (өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох, хүйс, төрсөн он, сар, өдөр, сургуульд суралцсан, суралшаж байгаа эсэх, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг, гэрлэлтийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан);

- Сүүлийн 7 хоног буюу тухайн үеийн идэвхи (эдийн засгийн болон эдийн засгийн бүс үйл ажиллагаа, түүнд зарцуулсан цаг, эдийн засгийн идэвхтэй, идэвхгүй

байдал, үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн статус, ажил мэргэжлийн ангиал, үндсэн ажлынхаа цалин хөлсийг ямар хугацааны давтамжтай авдаг, авч буй цалин, хөлс, орлого);

3. Нэмэгдэл ажил хийх хүсэл, боломж (нэмэгдэл ажил хийх хүсэл, боломжтой эсэх, ажил хэрхэн хайсан нэмэгдэл ажил хийх хүсэлгүй, боломжгүй байгаа шалтгаан);

4. Ажилгүйдэл (ажил хийхэд бэлэн байсан эсэх, эдийн засгийн идэвхгүй байсан шалтгаан, ажил хайсан хугацаа, ямар төрлийн/ажил мэргэжлийн ажил хийх хүсэлтэй байгаа, хичнээн төгрөгний цалин хөлс (өдрийн, сарын) авах бодолтой байгаа, хөдөлмөр, хalamж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн эсэх, бүртгүүлсэн хугацаа, сүүлийн 30 хоногт ажил хайсан эсэх, ажил хайсан хэлбэр, ажил хайгаагүй шалтгаан, ажилгүй байсан хугацаа);

5. Эдийн засгийн байнгын идэвхи (сүүлийн 12 сарын буюу эдийн засгийн байнгын идэвхи, сүүлийн 12 сарын хугацааны үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтийн статус, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, ажилгүй байсан хугацаа, ажил хайсан хэлбэр, сүүлийн 12 сард үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлтээс авсан дундаж цалин хөлс, орлого) ;

6. Өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт (өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн статус, ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хамгийн сүүлийн ажлаа хир удаан хийсэн, хамгийн сүүлчийн ажлаа хийхээ больсон шалтгаан, ажилгүй байх хугацаандаа ямар орлого, тусlamжаар амьдарч байгаа);

Судалгааны тоологч, ахлагч нар нь сонгогдсон өрхөд очиж 15 ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан. Монгол Улсад хүн амын шилжих хөдөлгөөн их байгааг харгалzan судалгаа авах үеэр өрх эзгүй байх тохиолдолд судалгаанд сонгогдсон өрхөө бүрэн хамруулахын тулд тухайн өрхөд 2-3 удаа очих тохиолдол олон байв. Түүвэрлэгдсэн өргүүдийг судалгаанд хамруулаж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж ажиллав. Судалгааны ажлын хэсгийн гишүүд, байгууллагын удирдлагуудаас бүрдсэн хяналтын баг АХС-ны ажлын явцыг хянаж шалган, гарсан ололт, дутагдлыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллав.

1.7. Мэдээлэл боловсруулалт

АХС-ны мэдээлэл боловсруулах ажлыг 2 үе шаттайгаар явуулсан. Судалгааны асуулгын загвар болон мэдээллийг компьютерт бэлтгэн оруулах, бүрдэлтийг шалган хүлээн авах, хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах

ажлуудыг YСХ-нд, харин өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт шивж оруулах, шалгах, улмаар засварыг хийсний дараа төвд дамжуулах ажлыг аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн ажиллах хүчний судалгаа хариуцсан ахлагч, мэргэжилтэн нар хийж гүйцэтгэсэн.

АХС-ны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлахад тоолмого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CSPro 3.1 багш программыг, бэлэн болсон мэдээллийн үр дүнг нэгтгэж боловсруулах, холбогдох хүснэгтүүдийг тооцож гаргах ажлыг SPSS13.0 программыг тус тус ашиглан, улмаар статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянах, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулсан.

1.8. Ойлголт тодорхойлолтууд

Судалгааны асуулгын хуудсанд тусгагдсан зарим үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолтуудыг 2009 оны 6 дугаар сард шинэчлэгдэн батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”, НҮБ болон ОУХБ-аас санал болгосон олон улсын нийтлэг стандарт бүхий ойлголт, тодорхойлолттой нийцүүлэн тусгасан. Ингэснээр энэ судалгааны үр дүнг YСХ-ноос явуулсан болон явуулж байгаа бусад судалгаа, бусад орны судалгааны үр дүнтэй зэрэгцүүлэн дүн шинжилгээ хийх боломжийг олгож байна.

Өрх

Өрх гэдэг нь байнга хамтран амьдарч, орлогоо нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол илдэг нэг буюу хэд хэдэн хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хамаатан садан болон ажил олгогчтойгоо хамтран амьдардаг, цусан төрлийн хамааралгүй, гэрийн үйлчлэгч, бусад хөлсний ажилчид ч байж болно.

Өрхийн тэргүүлэгч

Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн өрхийн гишүүн бөгөөд насанд хүрсэн хүн байна. Хэрвээ тухайн сууцанд нэгээс олон өрх амьдрлан сууж байвал төдий тооны өрхийн тэргүүн байна.

Эдийн засгийн үйл ажиллагаа

Зах зээлд болон хувийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг хамруулна. Үндэсний тооцооны системийн хүрээнд бараа, үйлчилгээнд худалдах, солилцох, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор боловсруулсан түүхий эд материал, зах зээлд нийлүүлж байгаа бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ, өөртөө хэрэглэх зорилгоор өрхөд үйлдвэрлэж байгаа бараа, үйлчилгээг хамруулна.

Энэ нь цалин хөлстэй болон цалин хөлсгүй, албан болон албан бус хэлбэртэй байж болно. Жишээлбэл, өөрийн өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцож буй хүнийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна гэж үзнэ.

Эдийн засгийн бус үйл ажиллагаа

Хүүхэд, өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олохгүй үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- Гэр орон цэвэрлэх, хувцас бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах;
- Хувцас угаах, индүүдэх, гэр байшин, эд хогшил сэргээн засах;
- Хоол унд хийх, аяга таваг угаах;
- Хүүхэд асрах;
- Өвчтэй хүн, өндөр настангуудыг асрах
- Гэрийнхээ хэрэгшиээт зүйлийг худалдаж авах, дэлгүүр явах

Ажиллагч

Ажиллагч гэдэг нь цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролсон бол ажиллагч гэж үзнэ.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Дангаараа буюу бусадтай хамтран өөрийн багаж, тоног төхөөрөмж, бусад материалыг ашиглан эдийн засгийн үйл ажиллагааг хараат бусаар явуулж, урт хугацаагаар ажилтан авч ажиллуулдаггүй (харин богино хугацаагаар түр авч ажиллуулж болно), бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрийг бие даан гаргадаг иргэнийг хэлнэ.

Мал аж ахуй эрхлэгч

Жилийн дөрвөн улирлын туршид өөрийн мал аж ахуйг эрхэлж, түүний бүтээгдэхүүн, ашиг шимээр орлого олж, амьжиргааны эх үүсвэрээ хангаж буй иргэнийг хэлнэ.

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч

Мал аж ахуйгаас бусад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролzon, хувийн хэрэглээгээ хангаж буй тухайн өрхийн гишүүн болон тухайн өрхөд хамт амьдрахгүйгээр аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд нь оролцож байгаа иргэнийг хэлнэ.

Ажилгүй иргэн

Тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

а/ “ажилгүй байсан” гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;

б/ “ажил хийхэд бэлэн” гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

в/ “ажил идэвхтэй хайж байгаа” гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

Байнгын болон тухайн үе

Энэхүү судалгаанд “тухайн үеийн” болон “байнгын” гэсэн хугацааг хэрэглэсэн. Тухайн үе гэдэгт судалгаа явагдаж байгаа үеийн өмнөх долоо хоног, өөрөөр хэлбэл сүүлийн долоо хоног, байнгын гэдэгт судалгаа явагдаж байгаа үеийн өмнөх 12 сар, өөрөөр хэлбэл сүүлийн 12 сар гэсэн хугацааг авсан болно.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)

Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангиана.

Эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам

Үрт хугацаагаар буюу сүүлийн арван сарын хугацаанд үндсэн үйл ажиллагааны шинж байдлаараа ажиллаж байсан болон ажилгүй байсан хөдөлмөрийн насны хүн амыг хамруулна.

Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам

Сүүлийн долоо хоногт эрхэлсэн үндсэн үйл ажиллагааны шинж байдлаараа ажиллаж байсан болон ажилгүй байсан нь тодорхойлогдох ажиллагч болон ажилгүй иргэдийг хамруулна.

Эдийн засгийн идэвхгүй хүн ам

Эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам болон хөдөлмөрийн насанда хүрээгүй хүн ам, хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа зургаан сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанда хүрээгүй хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амыг эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам гэж хоёр ангила.

Эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам

Үрт хугацаагаар буюу сүүлийн авван хоёр сарын хугацаанд эрхэлсэн үндсэн үйл ажиллагаагаараа эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцогдохгүй (ажиллагч болон ажилгүй иргэнд хамаарахгүй) хүн амыг, тухайлбал оюутан, сурагч, гэрийн ажилтай болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хүн амыг хамруулна.

Эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам

Сүүлийн долоо хоногт сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон болон өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагч болон ажилгүй иргэдийн алинд ч хамаарахгүй хүн амыг хамруулна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар

Тухайн хүний ажиллаж байгаа ажлын байр, үйлдвэрийн газар, байгууллагын үйлдвэрлэдэг үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр тодорхойлогдоно. Олон Улсын Стандарт Ангилал 4-т нийцүүлэн боловсруулсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг ашигласан.

Ажил мэргэжил

Цалин, хөлс, орлого олох зорилгоор тухайн хүний хийж гүйцэтгэж буй эдийн засгийн үйл ажиллагааны ажил, мэргэжлийн төрлийг ажил, мэргэжил гэнэ. Хэрвээ тухайн хүн ажилгүй байгаа бол эрхлэхэд бэлэн байгаа ажил, мэргэжлийн төрлийг тухайн хүний ажил, мэргэжил гэж үзнэ.

Үндсэн үйл ажиллагаа

Тухайн хүн хоёр болон түүнээс дээш төрлийн ажлыг хөлсөөр болон хувиараа эрхэлж байгаа бол тухайн хугацаанд хамгийн их цаг зарцуулсан эсхүл хамгийн их орлого олсон ажлыг хэлнэ.

Үндсэн ажил

Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлыг тодорхойлно. Хэрвээ тухайн хүн зөвхөн нэг л ажил эрхэлдэг бол түүнийг үндсэн ажилд тооцно.

Давхар ажил

Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлаас бусад ажлыг давхар ажил гэж тодорхойлно.

Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт

Тухайн хугацааны үндсэн үйл ажиллагаандaa ажлын цагийн тогтоосон доод хязгаараас бага цагаар ажилладаг эсхүл нэмэлт цагаар ажиллах хүсэлтэй бөгөөд ажиллахад бэлэн байгаа түүнчлэн тухайн хүний эзэмшсэн мэргэжил ур чадварыг бүрэн ашиглахгүй, бүтээмж доогуур байхыг хамруулна. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт нь ил, далд гэсэн хоёр хэлбэртэй байна.

Ажил олгогч

Эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шүүд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ.

Цалин хөлс

Мөнгөн болон биет хэлбэрээр авч байгаа хөлс, урамшуулал, гарын мөнгө, ашиг орлогын хувь, илүү цаг ажилласны мөнгө, ажил олгогчоос хангаж байгаа хоол хүнс, байрыг цалин хөлсөд хамааруулна.

Бичиг үсгийн мэдлэг

Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөртутмын амьдралын тухай хамгийн энгийн богино өгүүлбэрийг үншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзнэ. Харин аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран)

хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших, бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг бичиг үсэг мэддэггүй гэж үзнэ. Мөн уншдаг боловч бичиж чаддаггүй, өөрөөр хэлбэл унши, ойлгох, бичих чадварын аль нэгийг эзэмшээгүй тохиолдолд бичиг үсэг мэддэггүй гэж ойлгоно.

Оюутан

Тухайн хүний үндсэн үйл ажиллагаа нь их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа болон хичээлийг нь бие даан суралцагчдыг оюутан гэж үзнэ.

БҮЛЭГ II

**ХҮН АМ ЗҮЙН БОЛОН
ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

БҮЛЭГ II. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.1. Нийтлэг зүйл

Энэ бүлэгт АХС-ны дөрвөн улирлын турш (2010 оны 1 дүгээр сараас 2010 оны 12 дугаар сарыг дуусталх) нийт 1068 нэгжийн 12816 өрхөөс цуглуулсан мэдээлэл, түүн дээр үндэслэн тооцсон судалгааны үр дүнг танилцуулж байна. Түүвэрлэлтийн загварын дагуу тооллогын нэгж бүрээс 12 өрх, нийт 12816 өрх сонгогдон хамрагдаж, хамралтын түвшин 100.0 хувь байна.

ҮСХ-ноос энэхүү судалгааны тоо мэдээ, үр дүнг улирал тус бүрээр болон бүтэн жилээр нэгтгэн боловсруулдаг. Өөрөөр хэлбэл энэ тайлан нь улирал бүрээр болон дөрвөн улирлаар нэгтгэн боловсруулсан тоо мэдээ, үр дүнэд үндэслэсэн бөгөөд тайланда зөвхөн үндсэн үр дүнг харуулсан хүснэгтүүдийг оруулсан болно.

2.2. Хүн ам зүйн үзүүлэлтүүд

“Ажиллах хүчиний судалгаа”-гаар хүн амын тоо, насны бүлэг, хүйс, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэг, өрхийн ам бүлийн тоо, гэрлэлтийн байдал гэх мэт хүн ам зүйн холбогдолтой үндсэн үзүүлэлтүүдийг хот, хөдөөгөөр, дөрвөн бүс нутаг, Улаанбаатар хот гэсэн ангиллаар боловсруулав. Хүн ам зүйн үзүүлэлтүүдийг эдгээр ангиллаар тоошон боловсруулахад түүврийн нийт хэмжээг хангалттай гэж үзэж, дөрвөн улирлын нэгдсэн тоонд үндэслэн дэлгэрэнгүй хүснэгтүүдийн мэдээллийг байршилаар болон бүс, аймгаар боловсруулав.

2.3. Хүн амын тоо, байршил, бүс нутгаар

Судалгааны үр дүнг тархаасан тооцоогоор манай улсын 708.9 мянган өрхөд 2 сая 779.2 мянган хүн амьдарч байна. Нийт хүн амын 6.5 хувь буюу 179.4 мянган хүн 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байна. Эдгээр хүмүүс нь 109.7 мянган өрхийн гишүүд байна.

Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амыг тооцоходоо дотуур байр, цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар, эмнэлэг, сувилал зэрэг нийтийн байранд амьдрагчид, байнгын орон гэргүй хүн амыг хамруулаагүй болно.

Хүснэгт 2.1-д түүвэр судалгааны дүнг тархааж, тооцоолсон өрх, хүн ам, өрхийн ам бүлийн дундаж тоог байршил, бүсээр харуулав.

Манай улсын нийт өрхийн 60.0 хувь нь, хүн амын 58.1 хувь буюу 1628.3 мянга нь хот, суурин газарт амьдарч байна. Хүн амын байршилыг бүс нутгаар авч үзвэл 38.3 хувь нь нийслэл хотод, 21.9 хувь нь хангайн бүсэд, 18.1 хувь нь төвийн бүсэд, 13.7 хувь нь баруун бүсэд, 8.0 хувь нь зүүн бүсэд амьдарч байна. Өрхөөс гадуур 6 сараас дээш хугацаагаар амьдарч байгаа 179.4 мянган гишүүдийг

хамруулсан тооцоогоор өрхийн ам бүлийн дундаж тоо улсын дунджаар 3.9, хот, суурин газарт 3.8, хөдөөд 4.1 байна.

Хүснэгт 2.1. Өрх, хүн амын тоо, хот хөдөө, бүсээр

Байршил / Бүс	Өрх		Нийт хүн ам		Үүнээс:		Ам бүлийн дундаж тоо
	Тоо	%	Тоо	%	Өрхөд байгаа хүн амын тоо	Өрхөөс гадуур байгаа хүн амын тоо	
Хот	425245	60.0	1628333	58.6	1544319	84014	3.8
Хөдөө	283649	40.0	1151630	41.4	1056278	95352	4.1
Төв	128127	18.1	482595	17.4	443001	39594	3.8
Зүүн	56559	8.0	217497	7.8	209192	8305	3.8
Баруун	97007	13.7	435236	15.7	397176	38060	4.5
Хангай	155005	21.9	591058	21.3	546653	44405	3.8
Улаанбаатар	272196	38.3	1053577	37.9	1004575	49002	3.9
Дүн	708894	100.0	2779963	100.0	2600597	179366	3.9

АХС-нд нийтийн байранд амьдрагчид болон 6 сараас дээш хугашаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг хамруулаагүй болно. Өрхөөс 6 сараас дээш хугашаагаар гадуур байгаа гишүүдийн тоог хот, хөдөөгөөр болон бус нутгаар тооцож Хүснэгт 2.2-т үзүүллээ.

Хүснэгт 2.2. Өрхөөс гадуур 6 сараас дээш хугашаагаар байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөөгөөр, бүсээр

Хот, хөдөө /Бүс/	Өрхийн тоо	Өрхийн гишүүдийн тоо	Өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо	Үүнээс:		
				Суралшаж байгаа	Ажиллаж байгаа	Бусад
Хот	53738	185678	84014	38155	37169	8690
Хөдөө	55920	191795	95352	69737	13342	12273
Төв	25480	87695	39594	26123	7848	5621
Зүүн	5327	21210	8305	5349	1781	1175
Баруун	21898	82585	38060	29089	5446	3526
Хангай	26686	85363	44405	31278	6062	7065
Улаанбаатар	30267	100620	49002	16053	29374	3576
Дүн	109658	377473	179366	107892	50511	20963

Тухайн өрхийн гишүүн боловч 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа нийт 179.4 мянган хүн байгаа нь нийт хүн амын 6.5 хувийг эзэлж байна. Эдгээр гишүүдийн 24.8 хувь нь хангайн бүсэд, 22.1 хувь нь төвийн бүсэд, 21.2 хувь нь баруун бүсэд, 4.6 хувь нь зүүн бүсэд, 27.3 хувь нь нийслэл хотын өрхүүдэд харьяалтай байгаа ба тэдгээрийн 60.2 хувь нь буюу 107.9 мянган хүн сургууль, курст суралцаж, 28.2 хувь нь буюу 50.5 мянган хүн ажил эрхэлж байна.

Хүснэгт 2.3. Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр, хүйсээр


Байршил / Бүс	Өрх		Өрхийн ам бүлийн дундаж тоо	Бүгд	Үүнээс:			
	Тоо	%			Үүнээс: хүйсээр, %	Эрэгтэй		
						Эмэгтэй		
Хот	425245	60.0	3.6	1544319	48.3	51.7		
Хөдөө	283649	40.0	3.7	1056278	50.4	49.6		
Төв	128127	18.1	3.5	443001	49.4	50.6		
Зүүн	56559	8.0	3.7	209192	49.2	50.8		
Баруун	97007	13.7	4.1	397176	49.8	50.2		
Хангай	155005	21.9	3.5	546653	50.1	49.9		
Улаанбаатар	272196	38.4	3.7	1004575	48.2	51.8		
Үлсын дүн	708894	100.0	3.7	2600597	49.1	50.9		

Хүснэгт 2.3-т судалгаанд хамрагдсан хүн амын тоог хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр харуулав. Ам бүлийн дундаж тоог тодорхойлоход өрхөөс гадуур байгаа 179.4 мянган гишүүдийг хамруулаагүй болно.

2.4. Хүн амын нас, хүйсийн бүтэц

Хүн амын нас, хүйсийн бүтцийг Хүснэгт 2.4-т харуулав. Нийт хүн амын дотор 0-14 насны хүүхэд 28.3 хувийг эзэлж байгаа бөгөөд хүйсээр нь авч үзэхэд эрэгтэйчүүдийн 29.4 хувь, эмэгтэйчүүдийн 27.4 хувь нь энэ насны бүлэгт хамрагдаж байна. Хүн амын насны бүтцийг тухайн оны АХС-ны дүнгээр Зураг 2.1-д харуулав.

Зураг 2.1. Хүн амын насны бүтэц, АХС-ны дүнгээр



Судалгаагаар нийт хүн амын 67.7 хувийг 15-64 насны хүн ам, 4.0 хувийг 65, түүнээс дээш насны хүн ам тус тус эзэлж байна.

Хүснэгт 2.4. Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Хүйсийн харьцаа ¹
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	
00 – 04	245467	9.4	127185	10.0	118282	8.9	107.5
05 – 09	228873	8.8	115936	9.1	112937	8.5	102.7
10 – 14	262876	10.1	132166	10.3	130710	9.9	101.1
15 – 19	262106	10.1	133829	10.5	128276	9.7	104.3
20 – 24	251916	9.7	124842	9.8	127074	8.6	98.2
25 – 29	211521	8.1	103417	8.1	108104	8.2	95.7
30 – 34	200980	7.7	96416	7.5	104564	7.9	92.2
35 – 39	210077	8.1	99063	7.8	111014	8.4	89.2
40 – 44	197559	7.6	93094	7.3	104465	7.9	89.1
45 – 49	175429	6.7	84765	6.6	90664	6.9	93.5
50 – 54	131198	5.0	64066	5.0	67132	5.1	95.4
55 – 59	70579	2.7	34081	2.7	36498	2.8	93.4
60 – 64	48847	1.9	23717	1.9	25129	1.9	94.4
65 – 69	41194	1.6	20308	1.6	20886	1.6	97.2
70+	61977	2.4	24901	1.9	37076	2.8	67.2
Дүн	2600597	100.0	1277786	100.0	1322811	100.0	95.4

¹ 100 эмэгтэйд холбогдох эрэгтэйчүүдийн тоо

2.5. Хүн ам зүйн ачаалал

Хөдөлмөрийн насны бус хүн амын нийгэмд үзүүлэх ачааллыг хүн ам зүйн ачаалал гэж үздэг. Хүн ам зүйн ачааллыг 15 хүртэлх насны хүүхэд болон 65 ба түүнээс дээш насны хүн амын тооны нийлбэрийг 15-64 насны хүн амын тоонд харьцуулж тодорхойлох бөгөөд судалгааны дүнгээр хөдөлмөрийн насны 100 хүн тутамд хөдөлмөрийн насны бус 47.8 хүн ногдох байгаа нь 2009 (2009 онд 45.8) оны түвшнээс 2 хүнээр нэмэгдсэн байна. Хүснэгт 2.5-д Хүн ам зүйн ачааллыг байршил, бус нутгаар харуулсан бөгөөд хөдөлмөрийн насны хүн амд ногдох ачаалал улсын дунджаас хот, суурин газар болон Улаанбаатар хотод 5 хүнээр цөөн, зүүн, баруун болон хангайн бүсэд улсын дундажтай ойролцоо, харин хөдөөд 8 хүнээр олон байгаа бол төвийн бүсэд хамгийн олон буюу 15 хүнээр их байна. Эндээс харахад төвийн бүсэд хүн ам зүйн ачаалал хамгийн өндөр гарчээ. Дээр дурьдсанчлан энэхүү тооцоонд сургууль, курст суралцах зорилгоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа 107892 залуусыг хамруулаагүй болно.

Хүснэгт 2.5. Хүн ам зүйн ачаалал, хот, хөдөө, бүсээр

Хүн ам зүйн ачаалал	Бүгд	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	ҮБ
Залуу насны (0-14)	41.9	37.0	49.6	57.8	41.4	42.4	42.2	36.4
Ахимаг насны (65+)	5.9	5.9	5.7	4.8	5.8	5.9	5.9	6.2
Улсын дундаж	47.8	42.9	55.3	62.6	47.2	48.3	48.1	42.6

2.6. Гэрлэлтийн байдал

Судалгаагаар олон улсын аргачлалаар 15 ба түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг авч үздэг хэдий ч Монгол улсын “Гэр бүлийн тухай” хуулийн дагуу 18 ба түүнээс дээш насны хүн амаар тооцож, гэргэлтийн байдлыг гэрлэсэн, огт гэр бүл болоогүй, хамт амьдардаг, тусдаа амьдардаг, салсан, бэлбэсэн гэсэн 6 бүлгээр авч үзэв. 18 ба түүнээс дээш насны нийт хүн амын 61.8 хувь нь гэрлэсэн, 25.2 хувь нь огт гэр бүл болоогүй, 7.8 хувь нь бэлбэсэн байна. Харин 15 ба түүнээс дээш насны хүн амаар тооцож гэрлэлтийн байдлыг гаргавал, эдгээр насны хүмүүсийн 56.5 хувь нь гэрлэсэн, 31.6 хувь нь огт гэр бүл болоогүй байна. Гэрлэлтийн мэдээллийн үнэн зөвийг гэрлэсэн эрэгтэйчүүдийн тоо нь, гэрлэсэн эмэгтэйчүүдийн тоотой ойролцоо болон тэнцүү байгаа байдлаар үнэлдэг. Ингэж шалгаж үзэхэд гэр бүл болсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо хот, хөдөөд адил гарч байгаа нь судалгааны энэ асуултад өгсөн хариулт үнэн бодитой болохыг харуулж байна.

Хүснэгт 2.6. Хүн амын гэрлэлтийн байдал, хот, хөдөө, бүсээр, %

Гэрлэлтийн байдал	Бүгд			Хот		Хөдөө	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Огт гэр бүл болоогүй	25.2	28.0	22.7	28.5	24.1	27.2	20.2
Гэрлэсэн	61.8	63.7	60.0	62.3	56.4	65.9	66.2
Хамт амьдардаг	1.6	1.6	1.6	1.8	1.7	1.4	1.4
Тусдаа амьдардаг	1.5	1.3	1.7	1.6	2.4	0.7	0.6
Салсан	2.1	1.6	2.6	1.8	3.4	1.2	1.4
Бэлбэсэн	7.8	3.8	11.4	4.0	12.0	3.6	10.2
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
18 ба түүнээс дээш насны хүн амын тоо	1704936	821852	883084	496290	559177	325562	323907
Гэрлэсэн хүний тоо	1053345	523844	529501	309222	315156	214622	214345

2.7. Өрхийн бүтэц

Хүснэгт 2.7-д нийт өрхийн тоог ам бүлийн тоо болон хот, хөдөө, бүс нутгаар харуулав. Судалгааны дүнгээр өрхийн ам бүлийн тоонд өрхийн түр эзгүй байсан гишүүдийг оруулаагүйгээс шалтгаалж өрхийн ам бүлийн дундаж тоо нь доогуур гарсан байна. Нийт өрхийн 9.6 хувь нь нэг ам бүлтэй өрх, харин 5.6 хувийг 7 ба түүнээс дээш ам бүлтэй өрх эзэлж байна. Баруун бүсийн өрхийн ам бүлийн дундаж тоо 4.1 байгаа нь улсын дундаж болон бусад бүс нутгаас өндөр байгаагийн зэрэгцээ энэ бүсийн нийт өрхийн 9.6 хувийг 7 ба түүнээс дээш ам бүлтэй өрхүүд эзэлж байна. Түр эзгүй байгаа гишүүдийг оруулж тооцсоноор өрхийн ам бүлийн дундаж тоо Улаанбаатар хотод 3.9 байхад баруун бүсэд 4.6 (Хүснэгт 2.1-г үзнэ γγ) байна.

Хүснэгт 2.7. Өрхийн тоо, ам бүлийн тоогоор, байршилаар, бүсээр, %

Өрхийн ам бүлийн тоо	Үлсын дүн	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	ҮБ
1	9.6	9.4	9.9	11.5	10.0	6.7	10.1	9.3
2	15.3	14.8	15.9	17.8	16.0	11.4	16.9	14.4
4	25.4	26.6	23.5	25.1	22.7	23.5	25.2	26.9
5	14.7	14.6	14.7	12.7	14.7	18.0	13.3	15.1
6	6.8	6.2	7.7	5.4	8.3	10.8	5.7	6.5
7	3.5	2.7	4.8	3.1	4.7	6.8	2.6	2.8
8+	2.1	1.9	2.4	1.4	1.8	2.8	1.9	2.4
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Түр эзгүй байгаа хүнийг оруулаагүй өрхийн ам бүлийн дундаж тоо	3.7	3.6	3.7	3.5	3.7	4.1	3.5	3.7

2.8. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх

Судалгаагаар нийт өрхийн 20.8 хувь, хотын өрхийн 25.3 хувь, хөдөөгийн өрхийн 14.0 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувийн жинг ам бүлийн тоо болон хот, хөдөөгөөр Хүснэгт 2.8-д харуулав.

Хүснэгт 2.8 Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор, хот, хөдөөгөөр

Өрхийн ам бүлийн тоо	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх		
	Бүгд	Хот	Хөдөө
1	44.9	45.0	44.8
2	35.1	44.2	22.3
3	21.5	26.6	12.8
4	12.6	15.6	7.6
5	10.7	14.3	5.3
6	11.6	16.8	5.2
7	10.4	18.6	3.5
8+	14.7	21.3	6.5
Үлсын дундаж	20.8	25.3	14.0

Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд гол төлөв цөөхөн ам бүлтэй байгаагаас өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь хэмжээ багасч байна. Тухайлбал, нэг ам бүлтэй өрхийн 44.9 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байхад, 2-3 ам бүлтэй өрхийн 56.6 хувь, 4-6 ам бүлтэй өрхийн 34.9

хувь, 7-гоос дээш ам бүлтэй өрхийн 25.1 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байна.

2.9. Боловсролын түвшин

Судалгаагаар хүн амын эзэмшсэн боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэгийн талаарх мэдээллийг цуглуулсан. 15 ба түүнээс дээш насны хүн амын эзэмшсэн боловсролын түвшинг Хүснэгт 2.9-д харуулав. Хүснэгтээс харахад хот, хөдөөгийн алинд ч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзэмшсэн боловсролын түвшин бараг ойролцоо, гэхдээ эрэгтэйчүүдийн боловсролын түвшин эмэгтэйчүүдийнхээс арай дээгүүр байна. Хүснэгт 2.9-өөс харахад эрэгтэйчүүдийн 3.0 хувь, эмэгтэйчүүдийн 2.7 хувь нь боловсролгүй, эрэгтэйчүүдийн 10.5 хувь, эмэгтэйчүүдийн 9.7 хувь нь бага боловсролтой байна. Хөдөөгийн хүн амын 5.0 орчим хувь нь боловсролгүй, 17.9-19.3 хувь нь бага боловсрол эзэмшсэн байна. Хотын хүн амын 19.0-24.0 хувь нь, хөдөөгийн хүн амын 4.9-8.1 хувь нь бакалаврын болон магистрийн зэрэг эзэмшсэн байна. Хүн амын боловсролын түвшинг хот, хөдөөгөөр харьцуулж үзэхэд хөдөөд доогуур байна.

Хүснэгт 2.9. 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо боловсролын түвшингээр, хүйсээр, хот, хөдөөгөөр, %

Боловсролын түвшин	Бүгд			Хот		Хөдөө	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Боловсролгүй	2.8	3.0	2.7	1.4	1.5	5.4	4.8
Бага	10.1	10.5	9.7	4.7	4.8	19.3	17.9
Суурь	23.3	26.4	20.4	20.0	15.2	36.1	29.3
Бүрэн дунд	32.2	32.7	31.8	40.7	36.5	20.6	23.9
Мэргэжлийн анхан шатны	8.1	8.2	7.9	7.8	8.0	8.9	7.8
Дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд	7.7	5.9	9.4	6.5	10.2	4.9	8.2
Дээд/бакалавр	15.2	12.9	17.4	18.4	23.0	4.8	8.0
Магистр ба түүнээс дээш	0.5	0.4	0.6	0.6	1.0	0.1	0.1
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	1863383	902499	960884	541409	602793	361091	358089

2.10 Бичиг үсгийн мэдлэгийн түвшин

Судалгаанд хамрагдсан 15 ба түүнээс дээш насын хүн амын бичиг үсэгт тайлагдалтыг тодорхойлохын тулд “энгийн захияа үншиж, бичиж чадах уу” гэж асуух, энгийн бичиг захиаг үншиж, бичиж чадаж байвал бичиг үсэгт тайлагдсанда тооцсон болно. Харин зөвхөн өөрийнхөө нэрийг үнших эсвэл тоо үншиж чаддаг боловч бичиж чадлаггүй бол тэр хүнийг бичиг үсэгт тайлагдсанда тооцоогүй. Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын хувийг 15 ба түүнээс дээш насын нийт хүн амын дунд энгийн бичиг, захиа үншиж, бичиж чаддаг хүний эзлэх хувиар тодорхойлов. Хүн ам, орон сууцны 2010 оны тоологоор хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшин 98.3 хувь байгаа бөгөөд АХС-ны дүнгээр хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшин 0.7 пунктээр дээгүүр буюу 99.0 хувьтай байна.

Хүснэгт 2.10-т Хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшин хөдөөд 98.2 хувь байхад хотод үүнээс 1.2 пунктээр дээгүүр байгааг харуулж байна.

Хүснэгт 2.10. Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин, хот, хөдөө, бүсээр, хүйсээр

Хот, хөдөө /бүс	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Хот	99.4	99.5	99.4
Хөдөө	98.2	98.4	98.0
Төв	99.0	99.0	99.0
Зүүн	97.8	98.4	97.2
Баруун	98.2	98.4	98.1
Хангай	98.7	98.8	98.6
Улаанбаатар	99.6	99.6	99.5
Үлсын дүн	99.0	99.1	98.9

Хүснэгт 2.11-д 64 хүртэлх насын эрэгтэй, эмэгтэй хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшин 98-аас дээш хувьтай байна.

Хүснэгт 2.11. Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин, насын бүлгээр, хот, хөдөөгөөр, хүйсээр

Насны бүлэг	Үлсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15 – 24	99.0	98.9	99.1	99.3	99.1	99.4	96.7	97.2	96.2
25 – 34	98.7	98.6	98.8	99.5	99.3	99.6	97.7	97.5	97.9
35 – 44	99.4	99.5	99.3	99.0	98.6	99.3	98.3	98.8	97.9
45 – 54	99.3	99.4	99.2	99.7	99.5	99.9	98.2	98.3	98.2
55 – 64	99.6	99.7	99.5	99.1	99.6	98.7	99.0	99.4	98.7
65+	96.5	98.8	94.7	97.7	99.5	96.2	93.7	98.2	89.9
Δүн	99.0	99.1	98.9	99.4	99.5	99.4	98.2	98.4	98.0

2010

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА

БҮЛЭГ III

АЖИЛЛАХ ХҮЧ

БҮЛЭГ III. АЖИЛЛАХ ХҮЧ

3.1 Танилцуулга

Үндэсний Тооцооны систем(YTC)-д тодорхойлсны дагуу тодорхой шаг хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд ажиллах хүчээ нийлүүлж буй нийт хүн амьг эдийн засгийн идэвхтэй хүн ам гэж үздэг бол үйлдвэрлэл, үйлчилгээ гэдэгт бараа борлуулах, солиалцох болон өөрийн хэрэгшээнд зориулан бараа, бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг ойлгоно. Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчийг сүүлийн 7 хоногт ажил эрхэлж байсан болон ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан ажил хөдөлмөр идэвхтэй хайсан, ажилгүй байсан хүн ам бүрдүүлдэг. Сургуульд суралцдаг, гэрийн ажил хийдэг, тэтгэвэрт байгаа болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагчид болон ажилгүй иргэдийн алинд ч хамаарахгүй хүн амьг эдийн засгийн идэвхгүй буюу ажиллах хүчинд хамарагдахгүй хүн ам гэж үздэг.

Хэдийгээр Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжоор хөдөлмөр эрхлэх насыг 16-59 нас гэж заасан боловч ажиллах хүчний судалгаанд хүн амын эдийн засгийн идэвхийг 15 ба түүнээс дээш насаар тооцсон нь олон улсын аргачлалд нийцүүлж, бусад улс орны мэдээлэлтэй харьцуулах боломжийг бүрдүүлж өгч байгаа юм.

3.2 Ажиллах хүчний оролцооны түвшин

Судалгааны дүнгээр 15 ба түүнээс дээш насны 1863.4 мянган хүн байгаагийн 902.5 мянга буюу 48.4 хувь нь эрэгтэй, 960.9 мянга буюу 51.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам (ЭЗИХА) 1147.1 мянга буюу 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 61.6 хувийг эзэлж байна. Ажиллах хүч буюу ЭЗИХА-ыг сүүлийн 7 хоногт ажил эрхэлж байгаа болон ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхтэй хайсан ажилгүй хүн ам бүрдүүлдэг. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 90.1 хувь буюу 1033.7 мянга нь ажиллагчид, харин 9.9 хувь буюу 113.4 мянга нь ажилгүй иргэд байна. Нийт эдийн засгийн идэвхтэй хүн амын 54.0 хувь буюу 619.1 мянга нь хот, суурин газарт, 46.0 хувь буюу 528.0 мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна.

Хүснэгт 3.1. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хот, хөдөөгөөр, хүйсээр

Байршил/ Тухайн үеийн байдал	Үүнээс: хүйсээр					
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Toо	%	Toо	%	Toо	%
Улсын хэмжээнд						
Тухайн үеийн идэвхтэй хүн ам	1 147 146	61.6	606 843	67.2	540 303	56.2
Ажиллагчид	1 033 708	55.5	543 103	60.1	490 605	51.0
Ажилгүй иргэд	113 438	6.1	63 740	7.1	49 698	5.2
Тухайн үеийн идэвхгүй хүн ам	716 237	38.4	295 657	32.8	420 580	43.8
15 ба түүнээс дээш насны хүн ам	1 863 383	100.0	902 500	100.0	960 883	100.0
Хот						
Тухайн үеийн идэвхтэй хүн ам	619 110	54.1	326 868	60.4	292 242	48.5
Ажиллагчид	547 060	47.8	285 652	52.8	261 408	43.4
Ажилгүй иргэд	72 050	6.3	41 216	7.6	30 834	5.1
Тухайн үеийн идэвхгүй хүн ам	525 093	45.9	214 541	39.6	310 552	51.5
15 ба түүнээс дээш насны хүн ам	1 144 203	100.0	541 409	100.0	602 794	100.0
Хөдөө						
Тухайн үеийн идэвхтэй хүн ам	528 036	73.4	279 975	77.5	248 061	69.3
Ажиллагчид	486 648	67.7	257 451	71.3	229 197	64.0
Ажилгүй иргэд	41 388	5.7	22 524	6.2	18 864	5.3
Тухайн үеийн идэвхгүй хүн ам	191 144	26.6	81 116	22.5	110 028	30.7
15 ба түүнээс дээш насны хүн ам	719 180	100.0	361 091	100.0	358 089	100.0
Улсын хэмжээнд						
АХОТ*		61.6		67.2		56.2
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин		90.1		89.5		90.8
Ажилгүйдлийн түвшин		9.9		10.5		9.2
Хот						
АХОТ		54.1		60.4		48.5
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин		88.4		87.4		89.4
Ажилгүйдлийн түвшин		11.6		12.6		10.6
Хөдөө						
АХОТ		73.4		77.5		69.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин		92.2		92.0		92.4
Ажилгүйдлийн түвшин		7.8		8.0		7.6

*АХОТ = Ажиллах хүчний оролцооны түвшин

Хүснэгт 3.2 15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн байдлын зэрэгцүүлэлт

Эдийн засгийн идэвхийн байдал	Ажиллах хүчний судалгаа					2010 /ХАОСТ/
	2006-2007 /AXC+XXC/	2007-2008 /AXC+АБСС/	2008-2009 /AXC/	2009 /AXC/	2010 /AXC/	
А/ Хүн амын тоо, мян.хүн						
15, түүнээс дээш насны хүн ам	1 615.4	1 631.7	1 696.6	1 853.5	1 863.4	1 906.0
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	1 013.4	990.6	1 038.1	1 137.9	1 147.1	1 075.8
Ажиллагчид	898.9	899.8	933.9	1 006.3	1 033.7	911.7
Ажилгүй иргэд	114.5	90.8	104.2	131.6	113.4	164.1
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	602.0	641.1	658.5	715.6	716.3	830.2
Б/ Түвшин, хувиар						
Ажиллах хүчиний оролцоо	62.7	60.7	61.2	61.4	61.6	56.4
Хөдөлмөр эрхлэлт	88.7	90.8	90.0	88.4	90.1	84.7
Ажилгүйдэл	11.3	9.2	10.0	11.6	9.9	15.3

Ажиллах хүчиний болон Хүүхдийн хөдөлмөрийн 2006-2007 оны хавсарсан судалгаа, түүнчлэн 2007-2008, 2008-2009 оны Ажиллах хүчиний судалгааны нэгдсэн үр дүнгүүд ойролцоо гарч байгаа нь энэ судалгаануудад ОУХБ-аас гаргасан нийтлэг үзүүлэлтүүд, тэдгээрийн тодорхойлолт, арга зүйг ашигласантай холбоотой юм.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийг судалгааны онуудаар харьцуулан Хүснэгт 3.2-т үзүүллээ.

Ажиллах хүчиний 2009 оны судалгаагаар ажиллах хүчиний оролцооны түвшин (АХОТ) нь улсын хэмжээнд 61.4 хувь байсан бол 2010 оны судалгаагаар 61.6 хувьтай байна. Судалгаагаар АХОТ хот, суурин газарт 54.1 хувь, хөдөөд үүнээс харьцангуй өндөр 73.4 хувьтай байгаа нь хот, суурин газарт сургуульд хамрагдалтын түвшин хөдөө орон нутгийнхнаас өндөр байгаатай холбоотой юм. Иймээс хотод АХОТ хөдөөгийнхөөс 19.3 пунктээр доогуур (эрэгтэйчүүдийнх 60.4 хувь, эмэгтэйчүүдийнх 48.5 хувь) байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин /АХОТ/-г хөдөлмөрийн насны нийт хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувиар тодорхойлдог. Мөн ажиллагчид болон ажилгүй иргэдийн нийлбэр нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчийг бүрдүүлдэг.

$$\text{АХОТ} = \frac{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн ам}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100$$


$$\text{АХОТ} = \frac{\text{Ажиллагчид} + \text{Ажилгүй иргэд}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100$$

Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшинг доорх байдлаар тодорхойлно.

$$\frac{\text{Насны бүлэг дэх}}{\text{АХОТ}} = \frac{\text{Насны бүлэг дэх}}{(\text{Ажиллагчид} + \text{Ажилгүй иргэд})} * 100$$

$$\frac{\text{Насны бүлэг дэх}}{\text{Насны бүлэг дэх нийт хүн ам}}$$

Зураг 3.1-д АХОТ-г нийт дүнгээр, хот, хөдөө болон хүйсээр харуулнаа.



3.3 Насны бүлэг дэх оролцооны түвшин

Ажиллах хүчний оролцооны түвшин хоорондоо ямар ялгаатай байгааг харуулах зорилгоор 5 насны бүлгээр тооцож гаргадаг. Хүснэгт 3.3-т 15 ба түүнээс дээш насны хүн амын АХОТ-г нийт дүнгээр харуулав.

Ажиллах хүчний оролцооны түвшин 15-19 насанд 16.0 хувь байсан бол 25-29 насанд даруй өсч 75.7 хувьд хүрч, 30-44 насны бүлэгт 80.9-85.8 хувьтай байна. АХОТ нь 45-49 насны бүлгээс аажмаар буурч, 55-59 насанд 52.2, 60-64 насанд 27.1 хувь болсон байна. Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинд нөлөөлсөн. Бүх насны бүлэгт эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа бөгөөд хөдөө орон нутагт эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хот, суурин газрынхаас өндөр байна.


Хүснэгт 3.3. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин тухайн насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр

Насны бүлэг	Үлсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15-19	16.0	18.8	13.0	6.1	7.8	4.4	30.9	35.4	26.1
20-24	52.1	59.7	44.7	40.7	47.4	34.6	73.1	79.8	65.5
25-29	75.7	84.6	67.2	69.4	81.7	58.1	86.5	89.3	83.7
30-34	80.9	89.3	73.1	74.8	85.3	65.5	90.0	95.0	85.1
35-39	84.9	89.7	80.6	80.4	86.3	75.3	91.7	94.6	89.0
40-44	85.8	88.7	83.3	81.6	84.9	78.8	92.0	93.9	90.2
45-49	83.1	86.3	80.1	78.6	82.6	75.1	89.9	91.5	88.3
50-54	72.4	79.0	66.1	65.1	73.6	57.5	83.3	86.7	79.9
55-59	52.2	66.7	38.5	43.2	57.6	30.0	66.5	80.9	52.6
60-64	27.1	33.8	20.9	16.8	24.2	10.3	46.3	49.6	42.7
64-69	20.0	25.6	14.5	8.7	12.7	5.3	38.0	43.2	31.9
70 +	7.4	10.2	5.5	3.2	3.8	2.8	14.5	20.0	10.4
Үлсын дундаж	61.6	67.2	56.2	54.1	60.4	48.5	73.4	77.5	69.3

АХОТ эрэгтэйчүүдийн 25-44 насны бүлгүүдэд хөдөөд 89.3-93.9 хувь, хотод 81.7-84.9 хувь байгаа нь бусад насны бүлгүүдээс өндөр байна. АХОТ хотын эмэгтэйчүүдийн хувьд 40-44 насны бүлэгт хамгийн өндөр буюу 78.8 хувьтай байхад хөдөөгийн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин мөн энэ


насны бүлэгт хамгийн өндөр буюу 90.2 хувьтай байна. Энэ нь хот, суурин газрын эмэгтэйчүүд залуу насандaa сурч боловсрох, гэрийн ажил эрхлэх, хүүхэд төрүүлэх нь илүү байгаатай холбоотой байж болох юм (Зураг 3.2, 3.3-ыг үзнэ үү).

Зураг 3.2. Ажиллах хүчиний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр



Зураг 3.2-т насны бүлэг дэх АХОТ-г хүйсээр харуулав. Зургаас харахад 25-49 насандажиллах хүчиний оролцооны түвшин эрэгтэй, эмэгтэй хүмүүст адилхан өндөр 70.0 хувиас дээш байна. Мөн эдгээр насны бүлэгт эмэгтэйчүүдийн оролцооны түвшин ерөнхийдөө өндөр боловч эрэгтэйчүүдийнхтэй харьцуулбал бага зэрэг доогуур байна. Харин 40-44 насанд АХОТ эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хувьд нилээд ойролцоо байна.

Зураг 3.3. Ажиллах хүчиний оролцооны түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр



Хөдөө орон нутагт АХОТ өндөр байгаа нь тухайн үед хөдөөгийн эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо хот, суурингийн эдийн засгийн идэвхгүй хүн амын тооноос доогуур, түүний тэн хагаст ч хүрэхгүй байгаатай холбоотой.

Түүнчлэн хөдөө орон нутагт АХОТ хотынхаос өндөр байгаа нь өрхийн аж ахуйд суурисан нүүдлийн мал аж ахуй эрхлэлт их, мөн сургууль, боловсролын үйлчилгээний хүртээмж харьцангуй бага байдагтай холбоотой байж болох юм.

3.4 Эдийн засгийн идэвхгүй хүн ам

Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, ажил хайгаагүй, харин гэрийн ажилтай, тэтгэвэрт байгаа болон өндөр настан, сургуульд суралцдаг болон бусад шалтгааны улмаас эдийн засгийн идэвхгүй байсан нийт хүн амыг тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн ам буюу ажиллах хүчинээс гадуурх хүн амд хамруулдаг. Иймд сүүлийн 7 хоногт наад зах нь 1 цаг хөдөлмөр эрхлээгүй /эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй/, ажлын байргүй, ажил хийхийг хүсээгүй хүн амыг тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн амд тооцов.

Судалгаагаар 15 ба түүнээс дээш насны нийт 1863.4 мянган хүний 38.4 хувь буюу 716.2 мянга нь эдийн засгийн идэвхгүй бүлэглэлд багтаж байгаагийн 295.6 мянга нь эрэгтэйчүүд, 420.6 мянга нь эмэгтэйчүүд байна.

Эдийн засгийн идэвхгүй хүн амын 73.3 хувь буюу 525.1 мянга нь хот, суурин газарт, 26.7 хувь буюу 191.2 мянга нь хөдөө орон нутагт байна. Хөдөө орон нутагт ажиллах хүчиний оролцооны түвшин өндөр байгаа нь тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн амын тоог бууруулахад нөлөөлжээ. Тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй байдлыг гэрийн ажилтай, сургуульд суралцдаг, тэтгэврийнхэн болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, ажил хийхийг хүсээгүй, хүүхэд асардаг, өвчтэй байсан, өвчтөн, өндөр настан асарсан, бусад гэсэн шалтгаанаар ангилан харуулав.


Хүснэгт 3.4. 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам, идэвхгүй байгаа шалтгаан, дунд эзлэх хувиар, хүйс, байршилаар

Шалтгаан	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэрийн ажил	7.7	4.3	10.2	7.9	4.3	10.5	7.2	4.2	9.4
Суралцлаг	39.4	46.2	34.6	39.2	46.7	34.1	39.9	44.9	36.2
Тэтгэвэрт	20.2	18.1	21.6	20.6	18.6	22.0	18.9	16.8	20.5
Өндөр настан	2.4	2.1	2.6	1.3	1.1	1.4	5.6	4.7	6.1
Хөгжлийн бэрхшээлтэй	6.7	8.9	5.1	6.5	8.9	4.9	7.1	9.1	5.7
Ажил хийхийг хүсээгүй	1.4	1.9	1.0	1.5	2.0	1.0	1.2	1.8	0.9
Хүүхэд асарсан	9.6	1.5	15.3	10.7	1.8	16.8	6.6	0.6	10.9
Өвчтэй байсан	1.9	2.0	1.9	2.1	2.3	1.9	1.5	1.3	1.7
Өвчтөн, өндөр настан асарсан	-	0.1	-	-	-	-	0.1	0.2	-
Бусад	10.7	14.9	7.7	10.2	14.3	7.4	11.9	16.4	8.6
Дүн, (%)	100.0	100.0	100.0						
(Тоо)	716237	295657	420580	525093	214541	310552	191144	81116	110028

Эдийн засгийн идэвхгүй хүн амыг шалтгаанаар нь авч үзэхэд суралцагчид 282.3 мянга, өндөр настан, тэтгэврийнхэн 161.6 мянга, хүүхэд асардаг 68.6 мянга, гэрийн ажилтай 55.4 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 47.9 мянган иргэд, өвчтэй 13.8 мянга, хөдөлмөр эрхлэхийг хүсээгүй 9.9 мянга, өвчтөн, өндөр настан асарсан 5.3 мянга, бусад шалтгаантай 71.4 мянган хүн байна.

Нийт эрэгтэйчүүдийн 46.2 хувь, эмэгтэйчүүдийн 34.6 хувь нь сургуульд суралж байгаа гэж хариулсан нь эдийн засгийн идэвхгүй байгаагийн үндсэн шалтгаан болж байна. Эрэгтэйчүүдийн 20.2 хувь, эмэгтэйчүүдийн 24.2 хувь нь өндөр настай, тэтгэвэрт гарсан, 4.3 болон 10.2 хувь нь гэрийн ажилтай тул эдийн засгийн идэвхгүй байна.

Зураг 3.4. 15 ба түүнээс дээш насын эдийн засгийн идэвхгүй хүн амын бүтэц, шалтгаанаар



Хүн амын эдийн засгийн идэвхгүй байдлын үндсэн шалтгаан нь хот, суурин газарт болон хөдөө орон нутагт сурч боловсрох /хотод 39.4 хувь, хөдөөд 46.2 хувь/ мөн өндөр настан, тэтгэврийн асуудал байна.

Судалгаанд хамрагдсан хот, суурин газрын эдийн засгийн идэвхгүй хоёр эрэгтэй хүний нэг /46.7 хувь/ нь суралшаж буй, хөдөө орон нутгийн эдийн засгийн идэвхгүй 10 эмэгтэй тутмын 3 нь өндөр настан, тэтгэврийнх тул тус ажил хийдэггүй, хийх боломжгүй гэж хариулсан байна (Хүснэгт 3.4).

Ийнхүү эдийн засгийн идэвхгүй байгаа нийт хүн амын 22.6-39.4 хувийг тэтгэвэрт байгаа болон өндөр настан, сургуульд суралцдаг хүн ам эзэлж байна.

2010

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА

БҮЛЭГ IV

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

БҮЛЭГ IV. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

4.1. Тухайн үеийн ажиллагчид


Ажиллах хүчиний судалгаа нь Монгол Улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах зорилготой билээ. Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдээс сүүлийн 7 хоногт эрхэлсэн ажил, түүнд хичнээн цаг зарцуулсан талаар асуусан. Өвчтэй, амралттай байгаа, чөлөөтэй байсан, цаг агаарын бэрхшээл, ажил хаялт, хөдөлмөрийн маргаан болон бусад шалтгааны улмаас ажлын байртай боловч сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй хүн амыг энэ асуултад хамруулахын зэрэгцээ сүүлийн 7 хоногт наад зах нь нэг цаг ажилласан, эсвэл сүүлийн долоо хоногт ажлын байртай боловч ямар нэг шалтгаанаар ажлаа түр хийгээгүй хүн амыг тухайн үед хөдөлмөр эрхэлсэн гэж үзсэн.

Хүснэгт 4.1. Ажиллагчид, хүйс, хот, хөдөө, бүсээр

Байршил/ Тухайн үеийн байдал	Бүгд		Үүнээс: хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Toо	%	Toо	%	Toо	%
Хот	547 060	52.9	285 652	52.6	261 408	53.3
Хөдөө	486 648	47.1	257 451	47.4	229 197	46.7
Төв	195 443	18.9	103 835	19.1	91 608	18.7
Зүүн	71 957	7.0	37 872	7.0	34 085	6.9
Баруун	169 023	16.3	87 486	16.1	81 537	16.6
Хангай	236 401	22.9	123 523	22.7	112 878	23.0
Улаанбаатар	360 884	34.9	190 387	35.1	170 497	34.8
Дүн	1033 708	100.0	543 103	100.0	490 605	100.0

Судалгааны дүнгээр үлсын хэмжээнд тухайн үед нийт 1033.7 мянган хүн хөдөлмөр эрхэлж байсны 52.5 хувь буюу 543.1 мянга нь эрэгтэйчүүд, 47.5 хувь буюу 490.6 мянга нь эмэгтэйчүүд байна. Хүснэгт 4.1-ээс харахад тухайн үеийн ажиллагчдын 52.9 хувь нь хот, суурин газарт байгаагийн зэрэгцээ хөдөлмөр эрхэлсэн хүний тоо бус нутгуудаар ихээхэн ялгаатай байна. Нийт ажиллагчдын 34.9 хувь буюу 360.9 мянга нь Улаанбаатар хотод, 22.9 хувь нь хангайн бүсэд, хамгийн бага буюу 7.0 хувь нь зүүн бүсэд байна. Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлсэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тоо ойролцоо байна.

Зураг 4.1. Ажиллагчдын тоо, хүйс, хот, хөдөөгөөр (мян.хүн)



Хүснэгт 4.2. Ажиллагчдын тоо, хүйс, аймаг, нийслэлээр

Аймаг	Бүгд		Үүнээс: хүйсээр	
	Тоо	Хувь	Эрэгтэй	Эмэгтэй
Архангай	45 956	4.3	24452	21504
Баян-Өлгий	42 116	4.1	22208	19908
Баянхонгор	36 297	3.5	18295	18002
Булган	26 055	2.5	13762	12293
Говь-Алтай	28 183	2.7	14139	14044
Дорноговь	24 599	2.4	13485	11114
Дорнод	22 991	2.2	12199	10792
Дундговь	21 786	2.1	10905	10881
Завхан	33 194	3.2	17642	15552
Өвөрхангай	51 714	5.0	27785	23929
Өмнөговь	23 409	2.3	12050	11359
Сүхбаатар	26 273	2.5	14362	11911
Сэлэнгэ	46 139	4.5	24622	21517
Төв	39 865	3.9	21243	18622
Увс	32 912	3.2	17141	15771
Ховд	32 618	3.2	16356	16262
Хөвсгөл	48 429	4.7	24655	23774

Хэнтий	22 693	2.2	11311	11382
Дархан-Уул	34 691	3.4	19076	15615
Улаанбаатар	360 884	34.9	190387	170497
Орхон	27 950	2.7	14574	13376
Говьсүмбэр	4 954	0.5	2454	2500
Бүгд	1033 708	100.0	543 103	490 605

Тухайн үед хөдөлмөр эрхэлсэн хүн амын 34.9 хувь нь нийслэл хотод, 42.8 хувь нь зөвхөн 11 аймагт (Өвөрхангай-5.0, Хөвсгөл-4.7, Сэлэнгэ-4.5, Архангай-4.3, Баян-Өлгий-4.1, Төв-3.9, Баянхонгор-3.5, Дархан-Уул-3.4, Ховд, Увс, Завхан тус бүр 3.2 хувь) байна.

4.2 . Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилаар

Тухайн үеийн ажиллагчдын тоог, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилаар гаргаж Хүснэгт 4.3-т үзүүлэв.

Хүснэгт 4.3. Ажиллагчид, хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд		Үүнээс: хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Toо	%	Toо	%	Toо	%
ХАА, ан агуур, ойн аж ахуйн, загас барилт	346 574	33.5	188456	34.7	158118	32.2
Үүл уурхай, олборлолт	34 117	3.3	26427	4.9	7690	1.6
Боловсруулах үйлдвэр	64 772	6.3	32921	6.1	31851	6.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	12 395	1.2	9069	1.7	3326	0.7
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	7 790	0.8	4188	0.8	3602	0.7
Барилга	48 756	4.7	37859	7.0	10897	2.2
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	146 159	14.1	62710	11.5	83449	17.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	76 537	7.4	64940	12.0	11597	2.4
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	27 737	2.7	7255	1.3	20482	4.2

Мэдээлэл, холбоо	14 499	1.4	7319	1.3	7180	1.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	15 161	1.5	5637	1.0	9524	1.9
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	473	-	303	0.1	170	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	9 578	0.9	4845	0.9	4733	1.0
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	9 396	0.9	6155	1.1	3241	0.7
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн даатгал	61 036	5.9	35760	6.6	25276	5.2
Боловсрол	85 299	8.3	24016	4.4	61283	12.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	40 324	3.9	8659	1.6	31665	6.5
Үрлаг, үзвэр, тоглоом наадам	8 503	0.8	4390	0.8	4113	0.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	21 441	2.1	10903	2.0	10538	2.1
Хүн хөлслөн ажилуулдаг өрхийн үйл ажиллагаа	887	0.1	213	-	674	0.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2 274	0.2	1078	0.2	1196	0.2
Дүн, %		100.0		100.0		100.0
Тоо	1033 708		543 103		490 605	

Нийт хөдөлмөр эрхэлсэн хүн амын 33.5 хувь буюу 346.6 мянга нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаагийн 188.5 мянга нь эрэгтэйчүүд, 158.1 мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 4.2. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилааар, хувиар

Салбар



Мөн бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажиллагчид нилээд хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл нийт хөдөлмөр эрхлэгчдийн 14.1 хувь буюу 146.2 мянга нь энэ салбарт ажиллаж байна. Эдгээр салбарын дараа боловсролын салбар /8.3 хувь/, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа /7.4 хувь/, боловсруулах үйлдвэр /6.3 хувь/, төрийн удирдлага, батлан хамгаалахын үйл ажиллагаа, албан журмын нийгмийн даатгал /5.9 хувь/, барилга /4.7 хувь/ зэрэг салбарууд өндөр хувь эзэлж байна.

Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа, уул уурхайн олборлох аж үйлдвэр, байр сууц, хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа болон үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт нийт ажиллагчдын ердөө 0.1-3.9 хувь нь ажиллажээ.

4.3. Ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангилаар

Хүснэгт 4.4-т тухайн үед хөдөлмөр эрхэлсэн хүн амын тоог ажил мэргэжлийн ангилааар гаргаж харуулав. Нийт 58.9 мянган хүн хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерийн хөдөлмөр эрхэлж байгаа нь хөдөлмөр эрхэлж буй нийт хүн амын 5.7 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 4.4. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилаал, хүйсээр, дүндэгээс залж буй хувиар

Ажил мэргэжлийн ангилаал	Бүгд		Үүнээс: хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Toо	%	Toо	%	Toо	%
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежер	58 878	5.7	36 730	6.8	22 148	4.5
Мэргэжилтэн	135 923	13.1	46 444	8.5	89 479	18.2
Инженер, техникийн ажилтан	53 696	5.2	20 572	3.8	33 124	6.7
Бичиг хэргийн туслах ажилтан	19 164	1.9	5 641	1.0	13 523	2.8
Үйлчилгээний ажилтан	149 092	14.4	53 558	9.9	95 534	19.5
ХАА, загасны аж ахуйн ажилтан	336 275	32.5	181 804	33.5	154 471	31.5
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	117 231	11.3	76 162	14.0	41 069	8.4
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсралтч	94 674	9.2	89 571	16.5	5 103	1.0
Энгийн ажил мэргэжил	66 651	6.5	31 468	5.8	35 183	7.2
Бусад	2 124	0.2	1 153	0.2	971	0.2
Дүн, %		100.0		100.0		100.0
Toо	1033 708		543 103		490 605	

Улсын хэмжээгээр нийт 135.9 мянган мэргэжилтэн байгаагийн дийлэнх буюу 89.5 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөр эрхэлж буй зуун хүн тутмын арван гурав нь мэргэжилтэн байна.

Хөдөлмөр эрхэлж буй нийт хүн амын ихэнх буюу 336.3 мянга /32.5 хувь, үүний 154.5 мянга нь эмэгтэй/ нь хөдөө аж ахуйн болон загасны аж ахуйн холбогдолтой хөдөлмөр эрхэлж, 14.4 хувийг эзэлж буй үйлчилгээний ажилтны дийлэнх нь буюу 95.5 мянга нь эмэгтэйчүүд байна. Үйлдвэрийн ба худалдааны


чиглэлээр 117.2 мянган хүн, машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагчаар 94.7 мянган хүн ажилласан нь сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлсэн хүн амын 9.2 хувийг бүрдүүлжээ.

Хөдөлмөр эрхэлж буй арван хүний нэг нь үйлдвэрийн ба худалдааны ажилтан байна. Улсын хэмжээнд ажиллаж байгаа хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежер таван хүний гурав нь эрэгтэй байхад, арван мэргэжилтний долоо нь эмэгтэй байна.

4.4. Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар

Хөдөлмөр эрхлэлтийн статусыг 2009 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөгдөж буй YСХ-ны дарга, НХХ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчиний статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлал”-д заасны дагуу цалин хөлстэй ажиллагч, ажил олгогч, мал аж ахуй эрхлэгч зэрэг нийт 7 ангиалд хувааж үзэв.

Зураг 4.3. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, хувиар



Хөдөлмөр эрхэлж буй таван хүн тутмын хоёр нь цалин хөлстэй ажиллагч байхад хувиараа хөдөлмөр эрхлэгч, мал аж ахуй эрхлэгч тус бүр таван хүний нэг нь байна (Зураг 4.3).

Ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар нь хүйсээр авч үзвэл аль алинд нь цалин хөлстэй ажиллагч /эрэгтэй-38.5, эмэгтэй-46.8/ хамгийн их хувийг эзэлж байна. Түүнчлэн эмэгтэй ажиллагчдын дунд хувиараа хөдөлмөр эрхлэгч 18.7 хувийг эзэлж байхад эрэгтэйчүүдийн дунд 27.8 хувь, эмэгтэйчүүдийн дунд мал аж ахуй эрхлэгч 18.1 хувийг эзэлж байхад эрэгтэйчүүдийн дунд 27.2 хувь, эмэгтэйчүүдийн дунд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч 15.3 хувийг эзэлж байхад эрэгтэйчүүдийн 4.6 хувь байна.

4.5. Ажиллагчдын тоо, байгууллагын хариуслагын хэлбэрээр

Тухайн үеийн ажиллагчдын 22.9 хувь буюу 236.7 мянга нь мал аж ахуй эрхлэгч бөгөөд бусад байгууллагын ажиллагчдын тоог байгууллагын төрөл, бүс нутаг, хот, хөдөөгөөр Хүснэгт 4.5-д харуулав. Нийт ажиллагчдын 69.2 хувь буюу 551.6 мянга нь хувийн аж ахуйн нэгжид, 25.0 хувь буюу 198.9 мянга нь төсөвт байгууллагад, 3.9 хувь буюу 30.8 мянга нь төрийн өмчит үйлдвэрийн газарт, 1.4 хувь буюу 11.6 мянга нь төрийн бус байгууллагад, 0.5 хувь буюу 4.2 мянга нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт ажиллаж байна.

Хүснэгт 4.5. Тухайн үед хөдөлмөр эрхэлсэн 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, хот, хөдөө, бүс нутгаар

Ажил мэргэжлийн ангиалал	Бүгд		Үүнээс: байршил, бүсээр %							
			Байршилаар		Бүсээр					
	тоо	%	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ	
Төрийн өмчит үйлдвэрийн газар	30 790	3.9	3.9	3.7	6.7	5.4	1.0	2.2	3.9	
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	4 195	0.5	0.5	0.5	1.2	1.1	0.2	0.6	0.2	
Төсөвт байгууллага	198 867	25.0	23.8	27.2	24.1	30.6	31.8	25.7	22.3	
Төрийн бус байгууллага	11 577	1.4	1.8	0.9	0.7	1.1	1.3	1.2	2.0	
Хувийн аж ахуйн нэгж	551 557	69.2	70.0	67.7	67.3	61.8	65.7	70.3	71.6	
Дүн, %		100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	
Тоо	796 986		531 532	265 454	154 558	48 495	102 852	134 340	356 741	

Төсөвт байгууллагад ажиллагч таван хүний гурав нь хотод, хоёр нь хөдөө орон нутагт байна. Хөдөө орон нутгийн нийт хөдөлмөр эрхэлж буй хүн амын 67.7 хувийг хувийн аж ахуйн нэгжид ажиллагчид бүрдүүлж байна. Улаанбаатар хотод ажиллагч таван хүний нэг нь төсөвт байгууллагад, арван хүний долоо нь хувийн аж ахуйн нэгжид ажиллаж байна.

4.6. Давхар хөдөлмөр эрхлэлт

Судалгааны дүнгээр үндсэн ажлын хажуугаар давхар хөдөлмөр эрхэлж буй хүн амын талаар мэдээлэл цуглувансан. Давхар хөдөлмөр эрхэлж байгаа болон сүүлийн долоо хоногт давхар хөдөлмөр эрхлээгүй боловч тогтмол хийх давхар ажилтай нийт 24.8 мянган хүн байна. Сүүлийн 7 хоногт давхар хөдөлмөр эрхэлсэн хүн ам хөдөлмөр эрхэлж буй нийт хүн амын 2.4 хувийг эзэлж байна. Эрхэлж буй үндсэн ажлын үргэлжлэх хугацаа /цаг/ урт, цаг агаарын хүнд нөхцөл, эдийн засгийн өнөөгийн бүтэц зэргээс шалтгаалж, давхар хөдөлмөр эрхлэх бололцоо хязгаарлагдмал байж болзошгүй байна.

Хүснэгт 4.6. Сүүлийн 7 хоногт давхар хөдөлмөр эрхэлсэн хүн амын тоо, хүйс, ажил мэргэжлийн ангилаар

Ажил мэргэжлийн ангилаал	Бүгд		Үүнээс: хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Toо	%	Toо	%	Toо	%
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах аж	1 595	6.4	718	4.9	877	8.6
Мэргэжилтэн	1 635	6.6	372	2.6	1 263	12.3
Инженер, техникийн ажилтан	441	1.8	260	1.8	181	1.8
Бичиг хэргийн туслах ажилтан	375	1.5	252	1.7	123	1.2
Үйлчилгээний ажилтан	3 556	14.4	1 507	10.4	2 049	20.0
Хөдөө аж ахуй, загасны аж ахуйн ажилтан	6 589	26.6	3 922	27.0	2 667	26.1
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	5 751	23.2	3 627	24.9	2 124	20.8
Машин тоног төхөөрөмжийн операторч, угсралч	2 469	10.0	2 469	17.0	-	-
Энгийн ажил мэргэжил	2 345	9.5	1 407	9.7	938	9.2
Дүн	24 756	100.0	14 534	100.0	10 222	100.0


Давхар хөдөлмөр эрхэлж буй арван хүний гурав нь хөдөө аж ахуйн холбогдолтой хөдөлмөр эрхэлж байгаа бол таван хүний нэг нь үйлдвэрийн үйлдвэрийн ажилтан байна. Харин худалдаа, үйлчилгээний ажил, машин тоног төхөөрөмжийн операторч, угсралч болон энгийн ажил мэргэжлийн ажил тус

бүрийг хөдөлмөр эрхэлж буй арван хүний нэг нь давхар хашиж байна.

Давхар хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх буюу 83.7 хувийг ХАА, загасны аж ахуйн ажилтан, үйлдвэрийн ба худалдаа, үйлчилгээний ажилтан, машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч болон энгийн ажил мэргэжлийн ажилтан зэрэг дээрх 5 мэргэжлийн хүмүүс эзэлж байна.

Сүүлийн долоо хоногт давхар хөдөлмөр эрхэлсэн хүн амыг, давхар хөдөлмөр эрхэлсэн хугацаагаар нь авч үзвэл давхар ажлыг 10-аас дээш жил эрхэлсэн хүн хамгийн олон буюу 29.4 хувь, харин 1-2 жил эрхэлж байгаа 20.1 хувь, 5-9 жил давхар хөдөлмөр эрхэлсэн хүн 18.3 хувийг тус тус эзэлж байна. Давхар ажлыг 1 хүртлэх сарын хугацаанд эрхлэгчид хамгийн бага буюу 3.7 хувийг эзэлж байна.

Зураг 4.4. Сүүлийн 7 хоногт давхар хөдөлмөр эрхэлсэн хүн амын бүтэц, давхар хөдөлмөр эрхэлсэн хугацаагаар, хувиар



4.7. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт

2009 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөгдөж буй УСХ-ны дарга, НХХ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчиний статистик үзүүлэлтүүдийг тоошох аргачлал”-д бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Тухайн хугацааны үндсэн үйл ажиллагаандaa ажлын цагийн тогтоосон доод хязгаараас бага цагаар ажилладаг эсхүл нэмэлт цагаар ажиллах хүсэлтэй бөгөөд ажиллахад бэлэн байгаа түүнчлэн тухайн хүний эзэмшсэн мэргэжил ур чадварыг бүрэн ашиглахгүй, бүтээмж доогуур байхыг хамруулна.

Ажиллах хүчний судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар иж бүрэн мэдээлэлтэй болох, бүрэн бус хөдөлмөр эрхлэлт байгаа эсэх, түүнд ямар хүмүүс өртөж байгаа байдлыг судлахын тулд 15 ба түүнээс дээш насны тухайн үед хөдөлмөр эрхэлж байгаа буюу сүүлийн 7 хоногт нэг ба түүнээс дээш цаг цалин, орлого бүхий хөдөлмөр эрхэлсэн хүмүүсээс одоо хийж буй ажлаасаа гадна нэмэлт ажил хийх, хүсэл, боломж байсан эсэх, хэрэв байсан бол хэдий хугацаанд, нэмэгдэл ажлыг ямар арга замаар хайсан талаар мэдээлэл цуглувансан.

4.7.1. Тухайн үеийн бүрэн бус хөдөлмөр эрхлэлт

Хүснэгт 4.7-д нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой гэж хариулсан хүн амыг хүйсээр, мөн хот, хөдөө, бүсээр харуулав. Нэмэгдэл ажил хийх боломжтой гэж үзсэн 15 ба түүнээс дээш насны 37.9 мянган хүн /22.1 мянган эрэгтэй, 15.8 мянган эмэгтэй/ өөрсдийгөө бүрэн бус хөдөлмөр эрхэлж байна гэж үзжээ. Үүнээс харахад өөрсдийгөө бүрэн бус хөдөлмөр эрхэлж байна гэж харьцангуй цөөхөн хүн үзэж байгаа бөгөөд нийт ажиллагчдын дунд нэмэлт ажил хайсан хүний эзлэх хувь ердөө 3.7 хувь /эрэгтэйчүүдийнх 4.1 хувь, эмэгтэйчүүдийнх 3.2 хувь/ байна. Түүнчлэн бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн байдлыг хот, хөдөөгөөр авч үзэхэд хөдөө орон нутагт ажиллаж буй хүмүүс хотынхаос, харин бүсээр авч үзвэл баруун, төв болон хангайн бүсэд ажиллаж, амьдарч буй хүмүүс бусад бүсийнхийг бодвол илүүтэйгээр нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой байна.

Хүснэгт 4.7. Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой хүний тоо, хүйсээр, хот, хөдөө, бүсээр

Ажил мэргэжлийн ангилаал	Бүгд		Үүнээс: хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Toо	%	Toо	%	Toо	%
Хот	11 118	29.3	6 366	28.8	4 752	30.0
Хөдөө	26 826	70.7	15 763	71.2	11 063	70.0
Төв	9 445	24.9	5 690	25.7	3 755	23.7
Зүүн	1 928	5.1	1 032	4.7	896	5.7
Баруун	16 992	44.8	10 085	45.6	6 907	43.7
Хангай	8 872	23.4	5 051	22.8	3 821	24.2
Улаанбаатар	707	1.8	271	1.2	436	2.7
Үлсын дүн	37 944	100.0	22 129	100.0	15 815	100.0

Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой боловч эрхлээгүй байгаа шалтгааныг тодруулахад 87.1 хувь нь өөр ажил олж чадахгүй байсан, 5.0 хувь нь улирлын байдлаас шалтгаалсан, цаг агаар мую байсан, 1.3 хувь нь хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй, 0.3 хувь нь машин тоног төхөөрөмж эвдэрсэн, цахилгаан тасарсан болон 6.3 хувь нь бусад шалтгаанаар нэмэлт хөдөлмөр эрхлээгүй байна (Зураг 4.5).

Зураг 4.5. Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой ч эрхлээгүй шалтгаан, улсын дүнгээр, хувиар



Нийт нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой байсан хүн амын ажил хайсан хэлбэрийг сонирхвол 60.5 хувь нь нэмэлт ажил хайгаагүй, 12.0 хувь нь найз, нөхөл ба хамаатан садангаасаа асуусан бол 6.6 хувь нь мэдээллийн хэрэгслээр хайсан байна.

Хүснэгт 4.8. Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой хүний тоо, ажил хайсан хэлбэрээр, байршилаар

Ажил мэргэжлийн ангиал	Бүгд		Үүнээс: байршилаар, %	
	Тоо	%	Хот	Хөдөө
Хөдөлмөр, хalamж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн	1 597	4.2	6.0	3.5
Мэдээллийн хэрэгслээр хайсан	2 502	6.6	15.3	3.0
Ажил олгогчдод өргөдөл өгсөн	2 338	6.2	5.4	6.5
Ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандсан	244	0.7	0.5	0.7
Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаар явсан	1 609	4.2	6.5	3.3
Найз нөхөд ба хамаатнуудаасаа асуусан	4 556	12.0	17.0	9.9
Хувийн бизнесээ эхлэхэд газар, тоног төхөөрөмж, санхүүгийн эх үүсвэр хайсан	1 392	3.7	3.4	3.8
Нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар, тавих	170	0.4	1.0	0.2
Нэмэлт ажил хайгаагүй	22 960	60.5	43.9	67.4
Бусад	576	1.5	1.0	1.7
Дүн, %		100.0	100.0	100.0
Тоо	37 944		11 118	26 826

Ажил хайсан хэлбэрийг хот, хөдөөгөөр авч үзвэл нэлээд ялгаатай байна. Тухайлбал, нэмэгдэл ажил хайсан нийт хүн амын 29.3 хувийг хотынхон, 70.7 хувийг хөдөөнийхөн эзэлж байна (Хүснэгт 4.8).

Хүснэгт 4.9-д нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой байсан хугашааг байршил, бүс нутгаар харуулав.

Хүснэгт 4.9. Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой хүн амын тоо, хугацаа, хот, хөдөө, бүсээр


Ажил мэргэжлийн ангилаал	Бүгд		Үүнээс: байршил, бүсээр %							
			Байршилаар		Бүсээр					
	тоо	%	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ	
1 сараас бага	6.7	10.7	5.0	3.9	6.7	9.5	17.1	7.3	3.9	
1 - 2 сар	11.7	9.1	12.7	5.9	24.7	9.1	8.5	29.0	0.2	
3 -6 сар	20.6	19.4	21.2	23.2	21.6	17.2	15.5	7.8	22.3	
7-11 сар	4.9	4.5	5.1	2.6	7.1	7.8	0.0	6.1	2.0	
1 -2 жил	14.5	13.9	14.8	12.6	7.5	24.3	9.0	35.9	71.6	
3 ба түүнээс дээш жил	41.6	42.4	41.2	51.8	32.4	32.1	49.9	13.9	100.0	
Дүн %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	
Тоо	37 944	11 118	26 826	16 992	8 872	9 445	1 928	707		

Улсын хэмжээнд нийт нэмэлт ажил хийх боломжтой байсан хүн амын талаас илүү хувь нь 1 ба түүнээс дээш жилийн хугацаанд нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжтой байсан байна.

4.7.2 . Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан шалтгаан

Тухайн үед буюу сүүлийн долоо хоногт ажилласан 15 ба түүнээс дээш насны 1033.7 мянган хүний 995.8 мянга буюу 96.3 хувь нь нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан байна.

Зураг 4.6. 15 ба түүнээс дээш насны нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан хүний тоо, хүйс, хот, хөдөө, бүсээр /мян.хүн/




Нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй хүн амын 521.0 мянга буюу 52.3 хувь нь эрэгтэйчүүд, 474.8 мянга буюу 47.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 4.6-аас харахад хотын нийт ажиллагчдын 98.0 хувь нь, хөдөөгийн нийт ажиллагчдын 94.5 хувь нь нэмэлт хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан байна. Харин бус нутгаар авч үзэхэд Улаанбаатар болон хангайн бусад бусад бүсүүдээс харьцангуй олон хүн нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй гэж хариулсан байна.

Зураг 4.7-д нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан хүн амыг шалтгаанаар харуулав. Улсын хэмжээнд нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан хүн амын 92.7 хувь нь өөрийн эрхэлж буй ажлыг хангалттай гэж үзсэн байхад үлдсэн нь гэрийнхээ ажлыг хийдэг, жирэмсэн, хүүхдээ асарсан, суралшагч, төлбөргүй сургалтандаа хамрагдсан, амралт, улирлаас хамааран ажиллаагүй, түр өвчтэй болон бусад шалтгаантай байсан байна.

Зураг 4.7. 15 ба түүнээс дээш насны, нэмэгдэл хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан хүн, шалтгаанаар /хувиар/



БҮЛЭГ V

АЖИЛГҮЙДЭЛ

2010

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА

БҮЛЭГ V. АЖИЛГҮЙДЭЛ

5.1. Нийтлэг зүйл

2009 оны 6 дугаар сард шинэчлэгдэн батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчиний статистикийн үзүүлэлийг тооцох аргачлал” –ын дагуу:

“Ажилгүй иргэн” гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

а/ “ажилгүй байсан” гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;

б/ “ажил хийхэд бэлэн” гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

в/ “ажил идэвхтэй хайж байгаа” гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

5.2. Ажилгүй иргэдийн тоо

Судалгааны дүнг тархаасан тооцоогоор сүүлийн 7 хоногт ажил хайгаагүй, хөдөлмөр эрхлэхэд бэлэн, ажил хайсан ажилгүй иргэдийн тоо 113438 байгаагийн 56.2 хувь буюу 63740 нь эрэгтэйчүүд, 43.8 хувь буюу 49698 нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй таван хүний гурав нь хот суурин газарт амьдарч байна.

Хүснэгт 5.1. Ажилгүй иргэдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хүйс, хот, хөдөө, бүс нутгаар

Ажил мэргэжлийн ангилал	Ажилгүй иргэдийн тоо						Ажилгүйдлийн түвшин, хувиар		
	Бүгд		Үүнээс: Хүйсээр				Бүгд	Үүнээс: Хүйсээр	
			Эрэгтэй		Эмэгтэй			Эрэгтэй	Эмэгтэй
	Toо	%	Toо	%	Toо	%			
Хот	72 050	63.5	41 216	64.7	30 833	62.0	11.6	12.6	10.6
Хөдөө	41 388	36.5	22 524	35.3	18 865	38.0	7.8	8.0	7.6
Төв	19 977	17.6	11 814	18.5	8 163	16.4	9.3	10.2	8.2
Зүүн	8 408	7.4	3 955	6.2	4 453	9.0	10.5	9.5	11.6
Баруун	18 914	16.7	9 347	14.7	9 567	19.3	10.1	9.7	10.5
Хангай	31 874	28.1	18 283	23.8	13 591	27.3	11.9	12.9	10.7
Улаанбаатар	34 265	30.2	20 342	31.9	13 923	28.0	8.7	9.7	7.5
Дүн	113438	100.0	63740	100.0	49698	100.0	9.9	10.5	9.2

Ажилгүй иргэдийн тоог бүс нутгаар авч үзвэл ажилгүй арван хүний гурав нь хангайн бүсэд, харин нийт ажилгүй иргэдийн зөвхөн 7.0 хувь нь зүүн бүсэд амьдарч байна. Нийт ажилгүй иргэдийн 30.2 хувь буюу ажилгүй 34265 хүн Улаанбаатар хотод амьдарч байна. Ажилгүй иргэдийг хүйсээр нь бүс нутгаар авч үзэхэд зөвхөн Улаанбаатар хотод эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 18.8 пунктээр илүү (эмэгтэйчүүд 59.4 хувь, эрэгтэйчүүд 40.6 хувь) байгаа бол төвийн болон хангайн бүст эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс 14.7-18.3 пунктээр тус тус дээгүүр байна. Өөрөөр хэлбэл ажилгүйдэлд баруун, зүүн бүс болон Улаанбаатар хотын эмэгтэйчүүд, харин бусад бүс нутагт эрэгтэйчүүд илүү өртөж байна.

Хүснэгт 5.2-т харуулснаар нийт ажилгүй иргэдийн 59.4 хувийг 15-34 насын залуус, 34.0 хувийг 35-49 насынхан эзэлж байна. Нийт ажилгүй иргэдийн 23.1 хувь нь 20-24 насынхан байгаа бөгөөд, ажилгүй иргэдийн тоо цаашид буурч, 50-54 насандаа 4.9 хувь буюу 5505 болсон байна. Эндээс харахад залуу хүмүүс, ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орж буй хүмүүс ажилгүйдэлд илүүтэй өртөж байна. Ажилгүй эрэгтэй, эмэгтэй хүн амын насын бүтэц ерөнхийдөө төстэй байгаа хэдий ч 24 хүртэлх насын ажилгүй эрэгтэйчүүдийн эзлэх хувь тухайн насын

Эмэгтэйчүүдийн эзлэх хувиас 0.7-2.5 пунктээр илүү байгаа бол 25-44 насны бүлэгт Эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс өндөр байна.

Хүснэгт 5.2. Ажилгүй иргэдийн насны бүтэц, хувиар

Ажил мэргэжлийн ангилаал	Бүгд		Эрэгтэй %	Эмэгтэй %
	Toо	%		
15-19	7 512	6.6	6.9	6.2
20-24	26 183	23.1	24.2	21.7
25-29	19 156	16.9	16.1	16.3
30-34	14 500	12.8	12.0	13.8
35-39	15 359	13.5	13.1	14.1
40-44	11 956	10.5	9.6	11.7
45-49	11 378	10.0	8.8	11.6
50-54	5 505	4.9	5.6	3.8
55-59	1 887	1.7	2.4	0.7
Дүн %		100.0	100.0	100.0
Тоо	113438		63740	49698


5.3. Ажилгүйдлийн түвшин

Судалгааны дүнгээр ажил эрхлээгүй нийт хүн амаар тооцсон ажилгүйдлийн улсын дундаж түвшин 9.9 хувь байгаа бол ажилгүйдлийн түвшинг хүйсээр ялангуяа үзвэл эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 10.5 хувь, эмэгтэйчүүдийнх 9.2 хувьтай байна (Хүснэгт 5.1). Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 11.6 хувь буюу улсын дунджаас 1.7 пунктээр дээгүүр, харин хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин бага буюу 7.8 хувь болж, улсын дунджаас 2.1, хот суурин газрынхаас 3.8 пунктээр тус тус доогуур байна. Ер нь эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин улсын дунджаас доогуур, харин эрэгтэйчүүдийнх улсын дунджаас дээгүүр байгаа хандлага хот суурин, хөдөө орон нутагт адилхан харагдаж байна. Ажилгүйдлийн түвшин зүүн бүсэд 10.5 хувь, баруун бүсэд 10.1 хувь, хангайн бүсэд 11.9 хувь буюу улсын дундажаас 0.2-2.0 пунктээр дээгүүр байгаа бол бусад бүсийн хувьд улсын дундажаас 0.6-1.2 пунктээр доогуур байна.

Ажилгүйдлийн түвшинг насны бүлгээр нь авч үзвэл 15-19(18.0 хувь), 20-24 (20.0 хувь), 25-29(12.0 хувь) насны залуучуудын ажилгүйдлийн түвшин улсын дундажаас 2.1-8.1 пунктээр дээгүүр байна. Ажил эрхлээгүй 15-29 насны

залуучуудын ажилгүйдлийн түвшин бусад насны бүлгийн ажилгүй иргэдийн түвшингээс өндөр байгаа нь дараах зургаас (Зураг 5.1) харагдаж байна.

Зураг 5.1. Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр



Ажилгүйдлийн түвшинг насны бүлэг, хүйсээр нь авч үзэхэд 20-29, 35-44 насны, эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин тухайн насны эмэгтэйчүүдийнхээс арай өндөр, 15-19, 30-34, 45-49 насны эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр, 50-иас дээш насны бүлэгт эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Ажилгүйдлийн түвшинг хүйсээр нь авч үзэхэд 15-19, 30-34, 45-49 насны эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин нь эрэгтэйчүүдийнхээс 0.1-1.1 пунктээр илүү, харин бусад насны эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс 0.3-3.8 пунктээр өндөр байна. Эрэгтэйчүүдийн хувьд ажилгүйдлийн түвшин 15-24 насны бүлэгт 20.0 хувь хүртэл өссөнөө 25 наснаас эхлэн эргээд буурсан байна.

5.4. Ажилгүй иргэдийн боловсролын түвшин

Судалгааны дүнг тархаасан тооцоогоор нийт ажилгүй таван хүн тутмын нэг нь суурь боловсролтой, хоёр нь бүрэн дунд боловсролтой, нэг нь дээд боловсролтой байна. Гэтэл ажилгүй иргэдийн дунд боловсролгүй, бага боловсролтой хүний эзлэх хувь ердөө 7.7 хувь байна.

Хүснэгт 5.3. Ажилгүй иргэдийн боловсролын түвшин, хүйсээр, дүндэлэх эзлэх хувиар

Ажил мэргэжлийн ангиал	Бүгд	Үүнээс: Хүйсээр	
		Эрэгтэй	Эмэгтэй
Боловсролгүй	2.5	2.6	2.3
Бага	5.1	6.3	3.9
Суурь	22.9	26.7	18.0
Бүрэн дунд	38.2	38.8	37.4
Мэргэжлийн анхан шатны	10.7	9.4	12.3
Дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд	4.7	3.7	5.9
Дээд	15.9	12.5	20.3
Дүн, %	100.0	100.0	100.0
Тоо	113438	63740	49698

Боловсролгүй мөн бага боловсрол эзэмшсэн хүн олдсон ажлыг голохгүй хийдгээс тэдний дунд ажилгүйдлийн түвшин бага байгааг дараах зургаас харж болно.


Бага, суурь, бүрэн дунд боловсролтой болон боловсролгүй эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээсээ 1.8-2.5 пунктээр өндөр байхад, харин мэргэжлийн анхан шатны боловсролтой эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ажилгүйдлийн түвшин адилхан, дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд, дээд боловсролтой эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин тухайн боловсролын түвшинтэй эмэгтэйчүүдийнхээс 0.8-1.3 пунктээр өндөр байна.

Зураг 5.2. Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, боловсролын түвшингээр, хувиар



Дараах зурагт ажилгүйдлийн түвшинг аймгаар харуулав.

Зураг 5.3. Ажилгүйдлийн түвшин, аймаг, нийслэлээр, хувиар




Ажилгүйдлийн түвшин Дундговь, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар, Говьсүмбэр, Завхан, Увс, Булган, Өмнөговь, Дорноговь, Хөвсгөл, Орхон аймагт улсын дунджаас 0.2-16.0 пунктээр дээгүүр, бусад аймаг болон Улаанбаатар хотод 0.7-7.8 пунктээр доогуур байна.

5.5 Ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан

Ажилгүй иргэдийг ажилгүй байгаа шалтгаанаар нь авч үзвэл 63.9 хувь нь буюу 72.5 мянга нь ажил хайгаад ч олдоогүй, 23.5 хувь буюу 26.6 мянга нь ажил олдохгүй байх гэж бодсон, 2.9 хувь буюу 3.3 мянга нь улираас шалтгаалсан, 1.8 хувь буюу 2.0 мянга нь гэрийн ажилтай, 1.6 хувь буюу 1.8 мянга нь мэргэжил, дадлага байхгүй гэж хариулсан байна. Дээрх шалтгаанууд нь хөдөлмөр эрхлээгүй байгаа ажилгүй иргэдийн дийлэнх хувийг эзэлж байна (Зураг 5.1).

Зураг 5.4. Ажилгүй иргэд хөдөлмөр эрхлээгүй шалтгаанаар, хувиар



БҮЛЭГ VI

**АЛБАН БУС СЕКТОР ДАХЬ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

БҮЛЭГ VI. АЛБАН БУС СЕКТОР ДАХЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

6.1 Нийтлэг зүйл

Монгол Улсад албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлт нь хүн амын орлогын эх үүсвэр бүрдүүлэлтийн нэлээд хэсгийг хангадаг. Иймд ОУХБ-ын зөвлөмж болгосноор албан бус секторын талаарх тоо мэдээг статистикийн тогтолцооны нэг хэсэг болгож тогтмол цуглуулах нь зүйтэй гэж үзэж байна. Ингэснээр албан бус секторын цар хүрээ, хэмжээ, төлөв байдлын талаар байнгын мэдээлэлтэй болж, гарч буй өөрчлөлтөнд хяналт тавих боломжтой болох юм.

Хөдөлмөрийн Статистикчдийн Олон Улсын 15-р Бага Хурлаар батлагдсан “Албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлтийн статистикийн талаарх тогтоол” – д албан бус сектор дахь үйл ажиллагааг ямар үндэслэлээр хамруулах тухай шалгууруудыг тодорхойлон гаргаж өгсөн нь тухайн улс орны албан бус секторыг бодитойгоор тодорхойлсон ба улс орнуудын үндэсний хууль тогтоомжууд нь ялаатай байх зэргээс шалтгаалан албан бус секторын тодорхойлолт нь адил байх шаардлагагүй, шалгууруудыг янз бүрийн байдлаар хэрэглэж болно гэж заасан байдаг.

6.2 Тодорхойлолт

Олон улсын статистикийн болон YTC-ийн ойлголт тодорхойлолтонаа тулгуурлан “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.3-д заагдсан “Албан бус хөдөлмөр эрхлэлт гэдэгт албан ёсны бүртгэл, мэдээлэл, нийгмийн хамгаалал бүрэн хамрагдаагүй, хөдөө аж ахуйн бус, аж ахуй эрхлэх аливаа нэгэн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээг хувь хүн, өрх, хамтлаг эрхлэхийг хамруулна” гэсэн олон улсын нийтлэг шалгуур үзүүлэлтүүдийг багтаан өөрийн орны нөхцөл байдалд нийцрүүлэн тодорхойлсон. Өөрөөр хэлбэл албан бус сектор нь бүлэг аж ахуйн нэгж бөгөөд өрхийн аж ахуйн өөрийн үйлдвэрлэл буюу түүний эзэмшдэг хамтарсан бус аж ахуйн нэгж юм. Өрхийн аж ахуй нь (i) хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аж ахуй, (ii) албан бус секторт ажил олгогч эздийн аж ахуйгаас бүрдэнэ.

Албан бусаар хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аж ахуй гэдэг нь хувиараа хөдөлмөр эрхлэгч ганцаараа эсвэл өрхийн бусад гишүүд, өөр өрхтэй хамтран эрхэлж буй өрхийн аж ахуй бөгөөд өрхийн гишүүд болон түр хугацааны ажилтан хөлслөн ажиллуулдаг. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аж ахуй нь хөлсний ажилтныг тогтмол хугацаагаар ажиллуулдаггүй.

Албан бус секторт ажил олгогч эздийн аж ахуй гэдэг нь ганцаараа эсвэл бусадтай хамтран эрхэлж буй өрхийн аж ахуй бөгөөд нэг болон түүнээс дээш

тооны ажиллагчдыг тогтмол ажиллуулдаг. Ийм аж ахуйг тухайн улс орны нөхцөл байдалтай уялдуулан ажиллагчдын тоо болон улсын бүртгэлд бүртгэгдээгүй зэрэгт үндэслэн тодорхойлдог.

Албан бус сектор дахь ажил эрхлэлтийг тооцоходоо зах зээлд борлуулах зорилгоор бус, өөрсдийн хэрэглээ, хэрэгшээнд зориулан эрхэлж буй өрхийн аж ахуйг хамруулдаггүй. Албан бус сектор нь хөдөө аж ахуйн бус чиглэлээр ажиллаж буй өрхийн аж ахуйд л хамааралтай байж болох юм. Түүнчлэн дээр дурьдсан тодорхойлолтонд нийцэж байвал эмч, хуульч, нягтлан бодогч, инженер зэрэг мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг албан бус секторт хамруулах ёстой.

6.3 ХАА-н салбарын хөдөлмөр эрхлэлт

Хөгжиж буй орнуудын хөдөө аж ахуйн салбар дахь албан бус секторын үйл ажиллагааг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг тул ОУХБ нь ХАА-н салбарыг албан бус секторын хүрээнээс гаргаж, зөвхөн ХАА-н бус чиглэлийн үйл ажиллагааг тус секторт хамруулан тооцохоор тогтсон. Судалгааны дүнгээр Монгол Улсын нийт ажиллагчдын 33.5 хувийг шингээсэн ХАА-н салбар нь эдийн засгийн хамгийн том салбаруудын нэг бөгөөд ХАА-н салбар дахь үйл ажиллагаанд өрхийн жижиг аж ахуйн хэлбэр зонхилсон байдаг тус салбарыг албан бус секторт хамруулан тооцох ёсгүй юм. Ийм ч учраас ОУХБ-ын тодорхойлолтын дагуу ХАА-н бус салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг ХАА-н салбар дахь хөдөлмөр эрхлэлтээс зааглаж, улмаар ХАА-н бус салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг албан болон албан бус секторын гэж ангилан үзэх ёстой.

6.4 ХАА болон ХАА-н бус салбар дахь хөдөлмөр эрхлэлт

ХАА болон ХАА-н бус салбарын хөдөлмөр эрхлэлтийг Хүснэгт 6.1-д харуулав. Нийт ажиллагчдын 33.5 хувь буюу 346.6 мянган хүн хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа бөгөөд эдгээр хүмүүсийг албан бус секторын хүрээнд авч үзэхгүй. Гэсэн хэдий ч ХАА-н бус салбарт ажиллагчдын нэгэн адилар ХАА-н салбарт ажиллагчдын талаарх мэдээллийг оруулж байна.

Хүснэгт 6.1. ХАА болон ХАА-н бус салбарт тухайн үед ажилласан, 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, хүйсээр, хот, хөдөө, бүсээр

Байршил/ Бүс	Үлсын хэмжээнд			Үүнээс: салбараар	
	Бүгд	Үүнээс: Хүйсээр		ХАА	ХАА-н бус
		Эрэгтэй	Эмэгтэй		
Хот	547060	285652	261408	27759	519301
Хөдөө	486648	257451	229197	318815	167833
Төв	195443	103835	91608	70436	125007
Зүүн	71957	37872	34085	38629	33328
Баруун	169023	87486	81537	91914	77109
Хангай	236401	123523	112878	137000	99401
ҮБ	360884	190387	170497	8595	352289
Δүн	1033708	543103	490605	346574	687134
Хувиар					
Хот	100.0	52.2	47.8	5.1	94.9
Хөдөө	100.0	52.9	47.1	65.5	34.5
Төв	100.0	53.1	46.9	36.0	64.0
Зүүн	100.0	52.6	47.4	53.7	46.3
Баруун	100.0	51.8	48.2	54.4	45.6
Хангай	100.0	52.3	47.7	58.0	42.0
ҮБ	100.0	52.8	47.2	2.4	97.6
Δүн	100.0	52.5	47.5	33.5	66.5

Хүснэгтээс харахад ХАА-н бус салбарт ажиллагчдын нийт тоо 687.1 мянга /66.5 хувь/ байгаагийн 24.4 хувь нь л хөдөө орон нутагт, харин таван хүн тутмын дөрөв нь хот, суурин газарт төвлөрч байна. ХАА-н бус салбарт ажиллагчдын 51.3 хувь нь Улаанбаатар хотод байгаа нь албан бус хөдөлмөр эрхлэгчид нийслэл хотод олон байгааг харуулж байна.


6.5. Албан бус сектор дахь аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо

Байнгын орон тооны ажилчингүй, эсвэл 1-4 ажилтантай улсын өмчийнх бус, томоохон хувийн хэвшлийн аж ахуйд харьяалагдаггүй хөдөө аж ахуйн бус чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйг албан бус секторт хамруулж болох юм. Албан бус секторт орлого нь тодорхойлох боломжгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэгч гэж авч үзэж байна.

Хүснэгт 6.2. Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, хүйс, хот, хөдөө, бүсээр

Бүгд		Бүгд	Үүнээс: байршил, бүсээр							
			Байршилаар		Бүсээр					
			Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ	
Бүгд	Бүгд	154326	116991	37335	25873	23666	29508	6204	69075	
	Анхдагч	145698	114478	31220	22048	21786	27724	5364	68776	
	Хоёрдогч	8628	2513	6115	3825	1880	1784	840	299	
Эр	Бүгд	91077	68054	23023	17085	14010	17958	3656	38368	
	Анхдагч	85440	66350	19090	14504	12853	16718	3178	38187	
	Хоёрдогч	5637	1704	3933	2581	1157	1240	478	181	
Эм	Бүгд	63249	48937	14312	8788	9656	11550	2548	30707	
	Анхдагч	60258	48128	12130	7544	8933	11006	2186	30589	
	Хоёрдогч	2991	809	2182	1244	723	544	362	118	

Зураг 6.1. Албан бус сектор дахь ажиллагчид, хот, хөдөө, бүсээр, хувиар



Судалгааны дүнгээр 2010 онд улсын хэмжээнд албан бус секторт ажиллагчдын тоо 154.3 мянга байгаагийн 59.0 хувь буюу 91.1 мянга нь эрэгтэй, 41.0 хувь буюу 63.2 мянга нь эмэгтэй байсан ба 94.4 хувь нь үндсэн, бусад 5.6 хувь нь давхар хөдөлмөр эрхлэгчид байна.

Дээрх зургаас харахад албан бус секторт ажиллагчдын 75.8 хувь нь хот, суурин газарт, 24.2 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Харин албан бус секторт ажиллагчдын 44.8 хувь нь Улаанбаатар хотод, 19.1 хувь нь төвийн бүсэд, 16.8 хувь нь баруун бүсэд, 15.3 хувь нь хангайн бүсэд, 4.0 хувь нь зүүн бүсэд байна.

Хүснэгт 6.3. Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, аймаг, нийслэл, хүйсээр

Аймаг, нийслэлээр	Нийт			Үүнээс:	
	Бүгд	Хүйсээр		Үндсэн	Давхар
		Эрэгтэй	Эмэгтэй		
Архангай	5949	3447	2502	5543	406
Баян-Өлгий	5912	4689	1223	4995	917
Баянхонгор	7229	4113	3116	6193	1036
Булган	1931	1231	700	1703	228
Говь-Алтай	3219	2624	595	3169	50
Дорноговь	827	417	410	764	63
Дорнод	1608	889	719	1494	114
Дундговь	2168	1465	703	2008	160
Завхан	2157	1090	1067	2157	-
Өвөрхангай	1902	1373	529	1692	210
Өмнөговь	5610	3768	1842	4461	1149
Сүхбаатар	2195	1318	877	1914	281
Сэлэнгэ	4781	2935	1846	4781	-
Төв	4215	2460	1755	4028	187
Үвс	9367	5790	3577	7009	2358
Ховд	5218	2892	2326	4718	500
Хөвсгөл	2292	1182	1110	2292	-
Хэнтий	2401	1449	952	1956	445
Дархан-Уул	11103	6658	4445	10878	225
Улаанбаатар	69075	38368	30707	68776	299
Орхон	4363	2664	1699	4363	-
Говьсүмбэр	804	255	549	804	-
Бүгд	154326	91077	63249	145698	8628

Албан бус секторт ажиллагчдыг аймаг, нийслэлээр авч үзвэл Говьсүмбэр, Дорноговь аймагт тус бүр 0.5 хувь, Дорнод, Өвөрхангай, Булган, Дундговь, Завхан, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий аймгуудад 1.0-1.6 хувь, Говь-Алтай, Төв, Орхон аймгуудад 2.1-2.8 хувь, Сэлэнгэ, Ховд, Өмнөговь, Баян-Өлгий, Архангай аймгуудад 3.1-3.9 хувь, Баянхонгор, Увс, Дархан-Үүл аймгуудад 4.7-7.2 хувь, Улаанбаатар хотод 44.8 хувь нь байна.

6.6. Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Албан бус секторт ажиллагчдын тоог, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар Хүснэгт 6.4-т үзүүлмээ.


Хүснэгт 6.4. Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд		Үүнээс: хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Toо	%	Toо	%	Toо	%
Үүл уурхай, олборлолт	7540	4.9	5756	6.3	1784	2.8
Боловсруулах үйлдвэр	19940	12.9	11231	12.3	8709	13.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	55	0.04	55	0.1	-	-
Усан хангамж, бохир үс, хог, хаягдалийн менежмент болон цэвэрлэгээ	1223	0.8	741	0.8	482	0.8
Барилга	5175	3.3	4029	4.5	1146	1.8
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	74218	48.1	33818	37.1	40400	63.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	28999	18.8	27336	30.0	1663	2.6
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	5017	3.3	1004	1.1	4013	6.3
Мэдээлэл, холбоо	1028	0.7	645	0.7	383	0.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	448	0.3	250	0.3	198	0.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	53	0.03	53	0.1	-	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	309	0.2	309	0.3	-	-
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	754	0.5	380	0.4	374	0.6

Боловсрол	308	0.2	197	0.2	111	0.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	394	0.3	89	0.1	305	0.5
Үрлаг, үзвэр, тоглоом наадам	999	0.6	733	0.8	266	0.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	7397	4.8	4187	4.6	3210	5.1
Хүн хөлслөн ажилуулдаг өрхийн үйл ажиллагаа	469	0.3	264	0.3	205	0.3
Δүн %		100.0		100.0		100.0
Тоо	154326		91077		63249	

Албан бус секторт хөдөлмөр эрхэлсэн нийт хүн амын 48.1 хувь буюу 74.2 мянга нь, түүний дотор 33.8 мянган эрэгтэй, 40.4 мянган эмэгтэйчүүд бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажилласан байна. Мөн тээврийн ба агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагчид нилээд хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийн 18.8 хувь буюу 29.0 мянга нь энэ салбарт ажиллаж байна.

Зураг 6.2. Албан бус секторт ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар



6.7. Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангилаар

Хүснэгт 6.5-д албан бус секторт ажиллагчдын тоог ажил мэргэжлийн ангилаар харуулав.

Албан бус секторт хөдөлмөр эрхэлсэн нийт хүн амын ихэнх буюу 59.1 мянга /38.3 хувь/, үүнээс 35.8 мянган эмэгтэй худалдаа, үйлчилгээний ажил эрхэлсэн байна.

Нийт хөдөлмөр эрхлэгчдийн 28.1 хувийг үйлдвэрийн ажилчид эзэлж байгаагийн дийлэнх буюу 59.7 хувь нь эрэгтэйчүүд байна. Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсралтчар 29.4 мянган хүн ажилласан нь 19.1 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ мэргэжлээр эрэгтэйчүүдийн ихэнх буюу 30.9 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна.

Хүснэгт 6.5. Албан бус секторт дахь ажиллагчдын тоо, хүйсээр, ажил мэргэжлийн ангилааар

Ажил мэргэжлийн ангилаал	Бүгд		Үүнээс: хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Toо	%	Toо	%	Toо	%
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежер	3558	2.3	2224	2.4	1334	2.1
Мэргэжилтэн	2117	1.4	1345	1.5	772	1.2
Инженер, техникийн ажилтан	2815	1.8	1881	2.1	934	1.5
Бичиг хэргийн туслах ажилтан	912	0.6	388	0.4	524	0.8
Үйлчилгээний ажилтан	59140	38.3	23327	25.6	35813	56.6
Хөдөө аж ахуй, загасны аж ахуйн ажилтан	529	0.3	360	0.4	169	0.3
Үйлдвэрийн ба худалдааны ажилчид	43345	28.1	25864	28.4	17481	27.6
Машин тоног төхөөрөмжийн операторч, угсралч	29409	19.1	28153	30.9	1256	2.0
Энгийн ажил мэргэжил	12460	8.1	7535	8.3	4925	7.8
Бусад	41	0.03	-	-	41	0.1
Дүн %		100.0		100.0		100.0
Toо	154326		91077		63249	

БҮЛЭГ VII

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ

БҮЛЭГ VII. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ

7.1. Нийтлэг зүйл

Тус судалгааны нэг зорилго нь ажиллах хүчиний улирлын хэлбэлзлийг үндэсний, хэмжээнд болон хот, хөдөөгийн түвшинд судлан тогтоох явдал юм. Энэ зорилгын хүрээнд нийт түүврийн хэмжээг 4 улирлаар бүлэглэн тэнцүү хувааж, түүврийн сонголтыг 3 сар тутам буюу улирал бүрээр хангалттай хэмжээнд хийсэн болно. Нэг улиралд 3204 өрхийг түүвэрлэн хамруулж, нийт дөрвөн улирлын тоо мэдээг нэгтгэн үндсэн үзүүлэлтүүдийг тооцсоноос гадна улирал тус бүрээрх үндсэн үзүүлэлтүүдийн тооцоог энэхүү бүлэгт танилцуулж байна. Судалгаанд нийт 12816 өрхийн 47493 гишүүдийг хамруулж, судалгааны мэдээллийг 2010 оны 1 сараас 2010 оны 12 сарыг дуусталх хугацаанд 4 улирлаар цуглувулав.

7.2. Эдийн засгийн идэвхтэй хүн ам


Эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчийг улирлаар тооцож үзэхэд дөрвөн улирлын турш эдийн засгийн идэвхтэй хүн ам нэг их өөрчлөлтгүй, ойролцоогоор 1.1 сая гаруй байна.

Хүснэгт 7.1 . 15 ба түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх, улирлын тооцоогоор

Ажил мэргэжлийн ангилаал	2010 он				
	Улирал:				Жилийн дүн
	I	II	III	IV	
Ажиллах хүч	1 111 012	1 155 078	1 192 704	1 129 785	1 147 146
Эрэгтэй	582 668	607 305	636 976	600 421	606 843
Эмэгтэй	528 344	547 773	555 728	529 363	540 303
АХОТ,15+	61.1	62.1	61.7	61.3	61.6
Эрэгтэй	67.0	67.7	67.5	66.7	67.2
Эмэгтэй	55.7	57.0	56.2	56.1	56.2
Хот	53.3	55.2	53.8	54.0	54.1
Хөдөө	73.3	72.9	74.2	73.2	73.4
Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо	707 407	703 761	740 078	713 709	716 237
Эрэгтэй	287 139	290 093	306 221	299 174	295 657
Эмэгтэй	420 268	413 668	433 857	414 535	420 580
Хот	519 088	507 111	547 140	527 038	525 093
Хөдөө	188 319	196 650	192 938	186 671	191 144

Эдийн засгийн идэвхгүй хүн ам 1 дүгээр улиралд 707.4 мянга, 2 дугаар улиралд 703.8 мянга, 3-р улиралд 740.1 мянга, 4-р улиралд 713.7 мянга байсан байна.

Зураг 7.1 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, улирлаар (хувь)



Зураг 7.1-ээс харахад ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) нэг их өөрчлөгдөөгүй судалгааны 1 дүгээр улиралд хамгийн бага буюу 61.1, 2 дугаар улиралд хамгийн өндөр буюу 62.1 хувь, 3 дугаар улиралд 61.7 хувь, харин 4 дүгээр улиралд 61.3 хувьтай байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоон дахь хэлбэлзэл нь хөдөлмөр эрхэлсэн хүн амын тооны өөрчлөлттэй холбоогүй бөгөөд ажилгүй иргэдийн тоо буурсан нь хөдөлмөр эрхэлсэн хүний тоо нэмэгдэхэд хүргэжээ. Ажиллах хүчний нэг хэсэг буюу эдийн засгийн идэвхтэй хүн ам жилийн тодорхой хугацаанд эдийн засгийн идэвхгүй болж, тэдний оронд өөр хүмүүс эдийн засгийн идэвхтэй болох талтай. Гэхдээ өвлүүн улирал дуусахтай зэрэгцэн улирлын чанартай эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл бүрдсэнээр ажилгүй иргэдийн нэг хэсэг нь хөдөлмөр эрхэлж, хөдөлмөр эрхлэгч хүн амын тоог нэмэгдүүлж байгаа нь тодорхой байна.

7.3. Ажиллагчдын тоо


Хүснэгт 7.2-т ажиллах хүчний эрэлт хэрэгцээ нь улирлаар хэлбэлзэж буйг харуулж байна. 2010 оны 1 дүгээр улиралд 975.9 мянган хүн хөдөлмөр эрхэлсэн бол 2 дугаар улиралд 1045.7 мянга, 3 дугаар улиралд 1089.6 мянга болж өсч, 4 дүгээр улиралд буурч 1023.7 мянгад хүрсэн нь Монгол орны хувьд улирлын чанартай хөдөлмөр эрхэлдэгтэй холбоотой юм.

Хүснэгт 7.2. 15 ба түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлсэн хүн амын тоо, хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, улирлаар

Ажил мэргэжлийн ангиал	2010 он					Жилийн дүн	
	Улирал:				I		
	I	II	III	IV			
Тухайн үеийн ажиллагчдын тоо	975889	1045690	1089587	1023667		1033708	
Эрэгтэй	506335	547385	577450	541242		543103	
Эмэгтэй	469554	498305	512137	482425		490605	
Хот	500354	556936	570774	560175		547060	
Хөдөө	475535	488754	518813	463492		486648	
Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар:							
Хөдөө аж ахуй	323365	333780	403979	325174		346574	
Үйлдвэрлэл	139687	182162	179403	170065		160040	
Үйлчилгээ	512837	529748	506205	528428		527094	
Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр:							
Цалин хөлстэй ажиллагч	415526	443293	444189	453476		439121	
Ажил олгогч	11054	16655	10352	11622		12419	
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	227100	254234	252902	236895		242761	
Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин, хөлсгүй оролцогч	84531	107131	120455	86338		99607	
Мал аж ахуй эрхлэгч	235024	220077	258285	233527		236722	
Бусад	2654	4300	3404	1809		3078	

Манай улсын хүн амын хөдөлмөр эрхлэлт улирлаар нилээн хэлбэлзэлтэй байдаг хандлагыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь ангилан гаргасан дараах зургаас харж болно. Жилийн 2-3 дугаар улиралд манай орны хувьд хөдөө аж ахуйн салбар дахь эдийн засгийн үйл ажиллагаа (мал аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн холбогдолтой) өргөжих таатай боломж бүрдэж, өвлийн улирлаас зүн, намрын улирлын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэлбэлзэл их байгааг харуулж байна. Харин 4 дүгээр улирлын ХАА-н салбарын ажиллагчдын тооны бууралтанда ажил, сургуулийнхаа амралтын хугацаанд хөдөө орон нутагт ирж мал аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн холбогдолтой улирлын чанартай эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байсан залуус хичээл сургууль, ажил төрөлдөө эргэн орсон нь голлон нөлөөлсөн гэж үзэж байна.


Зураг 7.2. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбарууд, улираар



Харин үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын тоонд онцгой өөрчлөлт ажиглагдаагүй нь энэ салбарт хөдөлмөр эрхлэлтийн байдал улираар хэлбэлзэдэггүйг харуулж байна.

15 ба түүнээс дээш насын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн улсын дундаж түвшин хөдөө орон нутагт хот суурин газрынхаас 3.8 пунктээр илүү байгаа нь хөдөө аж ахуйн салбарт олноороо ажиллаж байгаатай холбоотой. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 3 дугаар улиралд хамгийн өндөр байна.

Зураг 7.3. 15 ба түүнээс дээш насын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хот, хөдөөгөөр, улираар




Хот, суурин газрын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин бүх улиралд хөдөө орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшингээс доогуур байгаа нь дээрх зургаас харагдаж байна.

7.4. Ажилгүй иргэдийн тоо

Судалгаагаар ажилгүйдлийн төлөв байдлын талаар мэдээлэл цуглуулан, ажилгүйдлийн үзүүлэлтүүд, цар хүрээг улирлын хэлбэлзлээр тооцов.

Зураг 7.4. Ажилгүйдлийн түвшин, хүйс, улирлаар, хувиар



2010 оны 1 дүгээр улиралд ажилгүйдлийн түвшин 12.2 хувь байснаа дараагийн улирлуудад буурсан хэдий ч хаврын улирал буюу 4 дүгээр улиралд 9.4 хувь болж, өмнөх 3-р улирлаас 0.8 пунктээр өссөн байна. Ажиллах хүчний улирлын хэлбэлзлээс хамаарч ажилгүйдлийн түвшин буурсан байна.

Хүснэгт 7.3. 15 ба түүнээс дээш насны ажилгүй иргэдийн тоо, хүйсээр, байршилаар, улирлаар

Ажил мэргэжлийн ангилал	2010 он				
	Улирал:				Жилийн дүн
	I	II	III	IV	
Ажилгүй иргэд	135122	109388	103117	106117	113438
Эрэгтэй	76333	59920	59526	59179	63740
Эмэгтэй	58789	49468	43591	46938	49698
Хот	92583	69034	67294	59287	72050
Хөдөө	42539	40354	35823	46830	41388
Ажилгүйдлийн түвшин, %	12.2	9.5	8.6	9.4	9.9
Эрэгтэй	13.1	9.9	9.3	9.9	10.5
Эмэгтэй	11.1	9.0	7.8	8.9	9.2
Хот	15.6	11.0	10.5	9.6	11.6
Хөдөө	8.2	7.6	6.5	9.2	7.8

Эрэгтэй, эмэгтэй хүн амын ажилгүйдлийн түвшин улирал бүрт ойролцоо байгаа бөгөөд 1 дүгээр улиралд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс 2.0 пунктээр бага байна. Харин хот, хөдөөгөөр авч үзвэл хөдөөд ажилгүйдлийн түвшин хот суурин газрынхаас ойролцоогоор 0.4-7.4 пунктээр доогуур байгаа нь хөдөө орон нутагт мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой хөдөлмөр голлон эрхэлж байгаатай холбоотой юм.

БҮЛЭГ VIII

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ
2007-2008, 2008-2009,
2009, 2010 ОНЫ СУДАЛГААНЫ
ҮНДСЭН ҮР ДҮНГИЙН
ХАРЬЦУУЛАЛТ**

БҮЛЭГ VIII. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ 2007-2008, 2008-2009, 2009, 2010 ОНЫ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

8.1. Нийтлэг зүйл

Монгол Улсад 2002-2003 онд анх удаа “Ажиллах хүчний судалгаа (АХС)”-г олон улсын жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Энэхүү судалгаа нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-с гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачлааар тоошох замаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодорхойлон, хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн холбогдолтой үзүүлэлтүүдийг улирлын нөлөөллийг нь тусган тооцож гаргасан.

2004 онд “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулж байх”-аар Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх, нөгөө талаас хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар нарийвчлан тогтмол судлах зорилгоор ОУХБ-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу 2006 оны 7 сараас эхлэн АХС-г улирлаар тогтмол явуулж байна.

Судалгааны түүврийн хүрээг Монгол Улсын хүн ам, өрхийн 2009 оны жилийн эцсийн мэдээнд үндэслэн тогтоосон бөгөөд судалгаанд нийт 12816 өрхийн 47493 гишүүнийг хамруулж, судалгааны мэдээллийг цуглуулав.

8.2. Хүн ам зүйн үзүүлэлтүүд

2010 оны АХС-ны түүврийн тархаалтын тооцоогоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа иргэдийг оруулаад Монгол Улсын нийт хүн ам 2.8 сая байна.

Хүснэгт 8.1 Өрх, хүн амын тоо, АХС-ны дүнгээр


Ажил мэргэжлийн ангилаал	Ажиллах хүчний судалгаа				Өсөлт, бууралт, %	
	2007-2008	2008-2009	2009	2010	<u>2010</u> 2007-2008	<u>2010</u> 2009
	VII.07-VI.08	VII.07-VI.08	I-XII	I-XII		
Өрхийн тоо	627 771	656 242	697 372	708 894	112.9	101.7
Нийт хүн амын тоо*	2 389 250	2 479 988	2 735 227	2 819 229	118.0	103.1
Өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо	134482	157775	173617	218632	162.6	125.9
Судалгаанд хамрагдсан хүн амын тоо	2 254 768	2 322 213	2 561 611	2 600 597	115.3	101.5
Үүнээс: насны бүлгээр						
0-14	623 085	625 635	708 089	737 216	118.3	104.1
15-64	1 528 992	1 592 469	1 754 058	1 760 212	115.1	100.4
65 ба дээш	102 692	104 108	99 464	103 171	100.5	103.7
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.8	3.8	3.9	4.0	105.1	102.6

* 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа өрхийн гишүүдийг хамруулсан.

Судалгааны дүнгээр үлсын хэмжээнд нийт 708.9 мянган өрх байгаа нь өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 1.7 хувь буюу 11.5 мянган өрхөөр нэмэгдсэн дүн гарлаа. Өрхийн ам бүлийн тоо сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байсан бол энэхүү судалгааны дүнгээр 4.0 болж өссөн байна.

Судалгааны үр дүнгийн тархаалтын тоошоогоор нийт хүн амын 28.3 хувийг 0-14 насны хүхэд, 67.7 хувийг 15-64 насны, 4.0 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн ам эзэлж байна. Хүн амын насны бүтцийг хүн ам, орон суушны 2010 оны тооллого болон АХС-ны үр дүнтэй харьцуулж үзвэл сүүлийн жилүүдэд нийт хүн амын тоонд 15-64 насны хүн амын эзлэх хувь тогтвортой нэмэгдэж, харин 0-14 насны хүхэд үүдийн эзлэх хэмжээ 2009 онд буурч, харин 2010 онд өссөн байна. Харин 65 ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин нэмэгдсэн хандлага ажиглагдаж байна.

Зураг 8.1 Хүн амын насны бүтэц, 2000, 2010 оны ХАОСТ, 2002-2003, 2006-2007, 2007-2008, 2008-2009, 2009, 2010 оны АХС-ны дүнгээр



8.3. Эдийн засгийн идэвхтэй хүн ам

2010 оны судалгааны түүврийн тархаалтын тооцоогоор 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо 1863.3 мянга болж, 2009 оны судалгааны дүнтэй харьцуулахад 0.5 хувь буюу 9.8 мянган хүнээр өссөн байна.

Хүн ам, орон сууцны тооллого болон Ажиллах хүчиний судалгаа нь зорилго, хамрах хүрээ, аргачлал, ойлголт, тодорхойлолт, ангилал, статистикийн нэгж, хамарсан үе, цаг хугацаа, нарийвчлал, хэмжигдэхүүн гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалсан онцлог ялгаатай учраас гарсан үр дүнгүүд ч гэсэн ялгаатай, тэдгээрийг хооронд нь шууд харьцуулах боломжгүй байдаг.

Тооллого нь хүн амын шинж, төрхийг бүхий л талаас судалсан тоо, мэдээллийг гаргах зорилготой бөгөөд 2010 оны тооллогоор, хүн амын эдийн засгийн идэвх болон идэвхгүй байдлын талаарх мэдээллийг 5 асуултын хүрээнд цуглуулсан мэдээлэлд үндэслэн тодорхойлсон. Харин Ажиллах хүчиний судалгаа нь эдийн засгийн идэвх болон идэвхгүй байдлын талаарх нарийвчилсан мэдээллийг бие биенээ шалгасан, уялдаа хамааралтай олон асуултаар цуглуулсан мэдээлэлд үндэслэн тодорхойлж байна.

Тухайлбал: Хүснэгт 8.2-д Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үр дүнгээр Монгол Улсад эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчийг 1 075.8 мянга, үүний 911.7 мянга нь ажил эрхэлж байгаа, 164.1 мянга нь ажил эрхлээгүй хүмүүс байна гэж гарчээ.

Хүснэгт 8.2 15 ба түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, АХС-ны дүнгээр


	Ажиллах хүчний судалгаа, мянган хүн				ХАОСТ 2010	Өсөлт, бууралт, %		
	2007-2008	2008-2009	2009	2010		2010	2010	
						2007-2008	2009	
15, түүнээс дээш насны хүн ам	1631.7	1696.5	1853.5	1863.3	1906.0	114.2	100.5	
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	990.6	1038.0	1137.9	1147.1	1075.8	115.8	100.8	
Ажиллагчид	899.8	933.8	1006.3	1033.7	911.7	114.9	102.7	
Ажилгүй иргэд	90.8	104.2	131.6	113.4	164.1	124.9	86.2	
Эдийн засгийн идэвхигүй хүн ам	641.1	658.5	715.6	716.2	830.2	111.7	100.1	

Энэ удаагийн судалгаанаас эдийн засгийн идэвхтэй хүн ам 1147.1 мянга болж өмнөх оноос 0.8 хувиар, ажиллагчдын тоо 2.7 хувиар өсөж, ажилгүй иргэдийн тоо 13.8 хувиар буурсан нь эдийн засгийн идэвхтэй хүн амын тооны өөрчлөлтөд нөлөөлжээ.

Харин Ажиллах хүчний судалгаагаар эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 1 147.1 мянга байгаагийн 1033.7 мянга нь ажиллагчид, 113.4 мянга нь ажилгүй иргэд байна. 113.4 мянган ажилгүй иргэдэд улирлын чанартай ажил хийдэг, мэргэжил, дадлага туршлага байхгүй, мэргэжилд тохиорох ажил олдохгүй, ажиллах сонирхолгүй гэх мэт шалтгаанаар сүүлийн 7 хоногт ажилгүй байгаа болон ажил идэвхтэй хайж байгаа (Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн, бүртгүүлээгүй) иргэдийг оруулсан. Энэ судалгаа нь өрхөд суурилсан учраас нийтийн байр буюу оюутны байранд амьдарч буй хүмүүс, цэрэг, хоригдлууд, гадаад оронд болон өрхөөс гадуур 6 сар ба түүнээс дээш хугацаагаар оршин суугаа монгол иргэд, Монгол Улсад 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа харьяалалгүй иргэд, Монгол Улсад 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа гадаадын харьят хүмүүсийг судалгаанд хамруулаагүй юм.

Иймд ойлголт, тодорхойлолт, аргачлалын зөрүүгээс гадна дээр дурдсан шалтгааны улмаас энэ удаагийн судалгааны дүнг 2010 оны ХАОСТ-ын үр дүнтэй шууд харьцуулах боломжгүй юм.

Зураг 8.2 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, АХС-ны дүнгээр



2010 оны АХС-ны дүнгээр ажиллах хүчний оролцооны улсын дундаж түвшин 61.6 хувьд хүрч, 2009 оны судалгааны дүнгээс 0.2 пунктээр өссөн нь ажиллагчдын тоо 1033.7 мянгад хүрч, өмнөх оны судалгаанаас 2.7 хувиар өссөнтэй холбоотой. Эрэгтэйчүүдийн АХОТ-н 0.5 пунктээр өссөн бол эмэгтэйчүүдийнх өмнөх оноос 0.3 пунктээр буурсан байна.

8.4. Ажиллагчдын тоо


Судалгааны дүнгээр 15 ба түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлсэн хүний тоог 2009 оны АХС-ны дүнтэй харьцуулахад 2.7 хувиар өсч, 1033.7 мянгад хүрчээ (Хүснэгт 8.3). Нийт хөдөлмөр эрхэлсэн хүн амыг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх судалгаатай харьцуулахад 6.2 пунктээр буурч, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 0.2 пунктээр өссөн байна. Ажиллагчдын тоог хот, хөдөөгөөр авч үзэхэд хот суурин газарт ажиллагчдын тоо өсч (2.9 хувь) 547.1 мянга, хөдөө орон нутагт ажиллагчдын тоо (2.5 хувь) 474.7 мянгад хүрч 2009 оноос өсчээ.

Хүснэгт 8.3 15 ба түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлсэн хүн амын тоо, 2007-2008, 2008-2009, 2009, 2010 оны АХС-ны дүнгээр

	Ажиллах хүчний судалгаа, мянган хүн				Өсөлт, бууралт, %	
	2007-2008	2008-2009	2009	2010	2010 2007-2008	2010 2009
Тухайн үеийн ажиллагчдын тоо	898932	899802	1006286	1033708	115.0	102.7
Эрэгтэй	463780	466052	526191	543103	117.1	103.2
Эмэгтэй	435152	433750	480095	490605	112.7	102.2
Хот	442498	423186	531583	547060	123.6	102.9
Хөдөө	456434	476616	474703	486648	106.6	102.5
Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар						
Хөдөө аж ахуй	373760	365229	348794	346574	92.7	99.4
Үйлдвэрлэл	123035	137022	156652	160040	130.1	102.2
Үйлчилгээ	402137	397551	500840	527094	131.1	105.2
Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар						
Цалин хөлстэй ажиллагч	374129	383426	401878	439121	117.4	109.3
Ажил олгогч	43696	11428	18501	12419	28.4	67.1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	260628	329750	237154	242761	93.1	102.4
Нөхөрлөл, хоршооны гишүүн	223	729	1392	752	337.2	54.0
Мал аж ахуй эрхлэгч	-	-	225336	236722	-	105.1
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин, хөлсгүй оролцогч	221126	208526	118429	99607	45.0	84.1
Эдгээр статуст хамрагдах боломжгүй ажиллагч	-	-	3596	2326	-	64.7

Ажиллагчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар нь авч үзэхэд 2010 онд 2009 оноос хөдөө аж ахуйн болон үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо өссөн бол, үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын тоо буурсан дүн гарчээ.


Зураг 8.3 Ажиллагчдын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын бүтэц, 2007-2008, 2008-2009, 2009, 2010 оны АХС-ны дүнгээр



Өмнөх оны хувьд ажиллагчдын эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбарын бүтцийг өмнөх судалгаануудын бүтэктэй харьцуулбал нийт ажиллагчдын дотор хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын эзлэх хувь өмнөх онуудад буурах хандлагатай байсаар байна. Үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарт ажиллагчдын хувийн жин жил ирэх тутам өссөөр байна (Зураг 8.3).

Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн статусыг ажиллах хүчиний сүүлийн 2 судалгаагаар харьцуулан авч үзэхэд 2010 онд нийт ажиллагчдын дотор мал аж ахуй эрхлэгчид болон цалин хөлстэй ажиллагчдын хувийн жин 0.5-2.6 хувиар өссөн байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогч, өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын хувийн жин 0.1-2.2 пунктээр буурсан байна (Зураг 8.4).

Зураг 8.4 Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдлын бүтэц, 2009, 2010 оны судалгааны дүнгээр



2010 оны судалгааны дүнгээр 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн улсын дундаж түвшин 90.1 хувь болж, өмнөх судалгааны дундаж түвшнээс 1.7 хувиар өссөн байна. Суурьшлаар авч үзвэл хот суурин газрын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 3.5 хувиар өсч 88.4 хувь болж, хөдөө орон нутгийнх 0.5 хувиар буурч 92.2 хувь болсон байна.


8.5. Ажилгүй иргэдийн тоо

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах ажлын хүрээнд олон төрлийн арга хэмжээ авч явуулж байгаагийн үр дүнд сүүлийн жилүүдэд ажилгүйдлийн түвшин буурч байгаа ба 2010 оны судалгааны дүнгээр 9.9 хувь болж өмнөх оноос 1.7 пунктээр буурсан байна (Зураг 8.5).

Мөн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 9.2-10.5 хувьд хүрч, 2009 оныхоос 1.1-2.4 пунктээр буурсан байна.

2010 оны судалгааны дүнгээр ажиллагчдын тоо 2.7 хувиар өссөн ч тухайн хугацаанд ажилгүй иргэдийн тоо 13.8 хувиар буурсан нь ажилгүйдлийн түвшинг буурахад нөлөөлжээ.

Зураг 8.5 Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, ажиллах хүчний судалгааны дүнгээр, хувиар



БҮЛЭГ IX

ТҮҮВРИЙН АЛДАА

БҮЛЭГ IX. ТҮҮВРИЙН АЛДАА

9.1 Нийтлэг зүйл

Судалгааны түүвэрлэлтийн нэгж нь өрх юм. Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгшээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас илүү хугацаагаар эзгүй байгаа (хугацаат шэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг өрхийн гишүүнд тооцохгүй.

9.2 Түүвэрлэлт

Ажиллах хүчиний түүвэр судалгааны бүлэглэлтийг засаг захиргааны нэгж буюу бүх аймаг, Улаанбаатар хотын дүүргүүд байхаар хийсэн. Энэ нь бодлого боловсруулагчадад хөдөлмөрийн статистикийн түлхүүр үзүүлэлтүүд, тухайлбал, ажилгүйдлийг аймаг, дүүргээр гаргаж өгөх боломжийг бүрдүүлэх юм. Улаанбаатар хотын хэмжээнд дүүргүүд түүврийн бүлэг болох бөгөөд хамгийн цөөн өрхтэй 2 дүүргийг нэг бүлэгт хамруулж нийт 8 бүлэг, аймаг тус бүрийг түүврийн нэг бүлэг хэмээн үзэж (21 аймаг) нийт 29 түүврийн бүлэг үүсгэсэн. Энд Улаанбаатар хотын дүүрэг, хорооны бүх хэсгүүд, аймгийн түвшинд сумын нийт багууд нь ТАШН болох юм. Ажиллах хүчиний түүвэр судалгаанд 12816 өрх хамрагдах бөгөөд улирал тутам 3204 өрх шинээр түүвэрлэгдэх болно. Судалгааны түүвэрлэлтийн хүрээ нь Монголын нийт өрх бөгөөд үнд Хүн ам, өрхийн 2009 оны жилийн эцсийн тайлан, мэдээний үр дүнг ашигласан.

Эхлээд түүврийн анхан шатны нэгжүүдийг аймаг, нийслэл сүм, дүүргийн нэрийн дагуу жагсааж ТАШН-ийн хувийн дугаар, нэгж бүрд тоологдсон өрхийн тоог жагсааж түүврийн хүрээг бэлтгэсэн.

Түүвэрт хичнээн өрх хамрагдах нь судалгааны санхүүжилтээс болон түүвэр судалгааны үр дүнгийн нарийвчлалаас ихээхэн хамаарна. Судалгаанд хамрагдсан 12816 өрхөөс авсан мэдээлэл нь монгол улсын нийт өрхүүдийг төлөөлөхдөө судалгааны асуулгаар цуглуулсан мэдээллийн бодит байдал үндэсний хэмжээнд 5 хувиас хэтрэхгүй алдааны магадлалтай ба түүвэрлэлтийн загварын нөлөөний утга нь 1.5-аас хэтрэхгүй байхаар түүвэрлэлтийг хийсэн.

Бүлэглэлт:

Улаанбаатар хотын хэмжээнд дүүрэг тус бүр түүврийн бүлэг болох бөгөөд хамгийн цөөн өрх, хүн амтай 2 дүүргийг нэгтгэн нэг бүлэг болгон нийт 8 бүлэг үүсгэсэн. Аймаг тус бүрийг нэг бүлэг хэмээн тооцож (21 аймаг) 21 бүлэг үүсгэсэн юм. Нийтдээ $21+8=29$ бүлэг 2 шаттай түүвэр хийсэн.

Бүлэг 1: УБ хотын 1-р дүүргийн бүх хэсгүүд
 Бүлэг 2: УБ хотын 2-р дүүргийн бүх хэсгүүд

.....

Бүлэг 7: УБ хотын 7-р дүүргийн бүх хэсгүүд
 Бүлэг 8: УБ хотын 8, 9-р дүүргийн бүх хэсгүүд
 Бүлэг 9: Архангай аймгийн бүх багууд
 Бүлэг 10: Баян-Өлгий аймгийн бүх багууд

.....

Бүлэг 29: Говьсүмбэр аймгийн бүх багууд

Түүвэрлэлтийг хийхдээ 2 шатат түүврийн аргыг хэрэглэсэн. Эхний шатанд ТАШН, хоёр дахь шатанд түүвэрлэгдсэн анхан шатны нэгж дэх өрхийг сонгосон. Түүвэрлэлтийн эхний шатанд судалгааны нэгж (баг, хорооны хэсэг) буюу түүврийн анхан шатны нэгжийг (ТАШН) түүвэрлэлтийн пропорциональ магадлалт системчилсэн түүврийн аргаар бүлэг тус бүрт түүвэрлэлт хийсэн. Ийнхүү түүвэрлэлт хийхдээ албан бус хөдөлмөр эрхлэлтийн сонгогдох магадлалыг нэмэгдүүлэх зорилгоор дэд бүлэглэлтийг хийж өглөө. Хувиараа хөдөлмөр эрхэлдэг ХАА-ын бус өрхийн хувийн жингээр тодорхойлогч үзүүлэлт болгон сонгож авсан.

Бүлэг доторх бүх судалгааны нэгжүүдийг аймаг, сум, баг, хорооны хэсгийн нэрийн дагуу жагсааж судалгааны нэгж бүрд тоологдсон өрхийн тоог тавьж түүврийн хүрээг бэлтгэсэн.

Хэмжээнд пропорциональ магадлалт түүврийн аргаар анхан шатны нэгжийг сонгоход ТАШН дэхь хүн амын тоо M_{hi} -г хэмжээний тодорхойлогч болгон ашигласан. Бүлэглэлт тус бүрээс хэмжээнд нь пропорциональ магадлалт системчилсэн түүврийн аргыг (ХПМСТ) түүвэрлэлт хийхэд хэрэглэсэн болно. Түүвэрлэлтийн үйл ажиллагааг дараах байдлаар үзүүлэв.

“ h ” бүлэг доторх ‘ i ’ ТАШН-ийн түүвэрлэгдэх магадлал дараах томьёогоор илэрхийлэгдэнэ.

$$P_{hi}^{(i)} = \frac{a_h M_{hi}}{M_h}$$

Үүнд:

a_h = бүлэг тус бүрээс авсан ТАШН-ийн тоо

$M_{hi} = i'$ ТАШН-д түүврийн хүрээнд тодорхойлогдсон хүн амын тоо

$M_h = \sum M_{hi}$ = бүлэг бүр дэх түүврийн хүрээгээр тогтоогдсон нийт хүн амын тоо

“ h ” бүлэг дэх ТАШН-үүдийг аймаг, сумын нэрийн дагуу жагсааж ТАШН-ийн түүвэрлэлтийг хийсэн ба тогтоогдсон хүн амын тоог хэмжээний үзүүлэлт болгож авсан юм. “ I_{hi} ” өсөн нэмэгдэх утгуудыг тооцоолж уг утгуудыг ТАШН тус бүрийн харалдаа тавьсан болно. Түүврийн интервал -ийг дараах байдлаар тооцоолсон.

$$I_{hi} = \frac{M_h}{a_h} \text{ хамгийн ойр бүхэл тоонд шилжүүлнэ.}$$

“ R_h ” санамсаргүй тоо нь 0-с I_{hi} хүртэлх дурын тоо байх ба үүнийг Excel программын санамсаргүй тооны функцийн тусламжтайгаар тодорхойлов.

“ a_h ” тодорхойлогч тоонуудын дарааллыг өмнөх сонгогдсон тоон дээр I_{hi} -г нэмж олсон болно.

$$R_h, (R_h + I_{hi}), (R_h + 2I_{hi}), (R_h + 3I_{hi}), \dots, (R_h + (j-1)I_{hi}), (R_h + (a_h - 1)I_{hi})$$

Хоёр дахь шатанд сонгогдсон ТАШН бүрээс түүвэр олонлогийг бүрдүүлэх өрхүүдийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгосон. ТАШН-үүдээс ирүүлсэн өрхийн жагсаалтад үндэслэн санамсаргүйгээр 12 өрхийг сонгож, судалгаанд хамруулсан.

Түүврийн жин

Түүврийн жин доорх томьёоны дагуу тодорхойлогдоно:

Δэд түүвэрлэлт тус бүр дэх түүврийн анхан шатны жинг тооцох томьёо

$$M_{srij} = \frac{P_s \times H_{srij}}{n_{sr} \times p_{sri} \times h_{srij}}$$

Δэд түүвэрлэлтийг нэгтгэсэн түүврийн анхан шатны нэгжийн жинг тооцох томьёо

$$M_{sij} = \frac{1}{2} \times \frac{P_s \times H_{srij}}{n_{sr} \times p_{sri} \times h_{srij}}$$

t-р улирлын жингийн томьёо

$$M_{tsij} = \frac{1}{2} \times \frac{P_s \times H_{srij}}{n_{tsr} \times p_{sri} \times h_{srij}}$$

P, p, n, H & h-ийн утгууд

P – тухайн бүлгийн хэмжээ буюу бүлгийн нийт хүн амын тоо.

p – тухайн анхан шатны нэгжэс дэх нийт хүн амын тоо

n – тухайн дэд түүвэрлэлтээр тоологдох түүврийн анхан шатны нэгжийн тоо

H – тухайн бүлгийн анхан шатны нэгжийн дэд түүвэрлэлт дэх өрхийн нийт тоо.

h – тухайн бүлгийн анхан шатны нэгжийн дэд түүвэрлэлт дэх түүвэрлэгдэх өрхийн тоо.

Вариац болон стандарт алдааны тооцоо

Судалгааны үр дүнгийн нарийвчлал, төлөөлөх чадварыг гаргах нь тооцооны зайлшгүй хэсэг юм.

Тухайн сонгож авсан у үзүүлэлтийн вариацыг тооцох томъёо:

$$\text{var}(y) = \sum [(1 - f_h) (a_h / a_h - 1) \sum (y_{hi}^2 - y_h^2 / a_h)]$$

Үүнд

f_h = “*h*” бүлгийн түүврийн хувь

a_h = “*h*” бүлгээс түүвэрлэсэн ТАШН-ийн тоо

y_{hi} = *h* бүлгийн *i* тооллогын нэгжийн у үзүүлэлтийн утга

Судалгааны үр дүнгийн стандарт алдааны утга нь түүвэр хийснээс шалтгаалан ерөнхий олонлогийн бодит утга буюу параметрээс түүврийн утга хэр зэрэг хэлбэлзэж байгааг үзүүлнэ. Стандарт алдааг $se(y)$ түүврийн үндсэн дээр тооцоходоо:

$$se(y) = \text{var}(y)^{1/2}$$

Харьцангуй стандарт алдаа буюу вариацын коэффициент нь *cv*, түүврийн тооцооны утгын харьцангуй вариацын утгыг илэрхийлэх ба өөрөөр хэлбэл түүврийн алдаа нь тооцооны утгатайгаа харьцуулахад ямархуу далайштай байна гэдгийг үзүүлнэ. Вариацын коэффициентыг доорхи аргаар тооцно.

$$cv(y) = se(y) / y.$$

Дундаж, харьцаа гэх мэт үзүүлэлтийн тооцооны утгын далайц, хэмжих нэгж нь өөр өөр байдгаас хамааран тухайн судлагдаж байгаа үзүүлэлтийн талаар хийгдсэн янз бүрийн судалгааны үр дүнгийн стандарт алдаануудыг шууд харьцуулах боломжгүй учраас *cv* буюу пропорциональ алдаа нь төлөөлөх чадварыг харьцуулах боломж олгодог. Түүврийн хэмжээ болон түүврийн арга нь түүврийн алдаа хэр зэрэг их, бага байхыг тодорхойлох бөгөөд зарим үзүүлэлтийн хувьд түүврийн алдаа өндөр байх боломжтой бөгөөд эдгээр тоог ашиглахдаа анхааралтай байх хэрэгтэй.

9.3 Түүврийн алдаа

Түүвэр судалгаа хийгдэж байгаатай уялдан дараах 2 төрлийн алдаа гарч байдаг. Үүнд

- 1) түүвэрлэлтийн алдаа;
- 2) түүвэрлэлтийн бус алдаа;

Түүвэрлэлтийн бус алдаа нь тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах үйл явцын үед гардаг. Энэхүү алдаанд судалгааны бэлтгэл үе шат, мэдээлэл цуглуулах үед хийсэн тоологч, мэдээлэгчийн санамсаргүй болон санаатай хийсэн алдаа, боловсруулалтын шатанд гарсан алдааг хамруулж авч үздэг. Түүвэрлэлтийн бус алдаа нь түүврийн үр дүнгийн алдааны ихэнх хувийг эзэлдэг бөгөөд түүврийн дизайн болон түүвэр судалгааг явуулах үе шатуудаас хамаардаггүй. Түүвэрлэлтийн бус алдаа нь гарсаар байдаг бөгөөд судалгааг явуулах бүхий л үе шатанд багасгах арга хэмжээг авдаг. Нөгөөтэйгүүр түүвэрлэлтийн бус алдааг статистикийн аргаар тооцоолох боломж хомс байдаг. Харин түүвэрлэлтийн алдааг статистикийн аргаар тооцолдог.

Нийт олонлогоос түүвэрлэн авсан ажиглалт дээр тулгуурлан үр дүнг тооцдогоос улбаалан түүвэрлэлтийн алдаа гардаг. Түүвэрлэлтийн алдаа тухайн судалгааг хийхэд ашигласан түүврийн төрөл болон түүврийн хэмжээнээс хамаарна. Энэхүү алдааг боломжит түвшинд байлгах үүднээс түүврийн загварыг болон түүврийн хэмжээг сонгосон.

Улсын хэмжээнд тодорхойлогдсон түүврийн анхан шатны нэгж бүрээс тус түүвэрт сонгогдсон түүврийн нэгжээс судалгаа авч үр дүнг тооцсонтой холбоотойгоор судалгааны үр дүн бодит утгаас ямар хэмжээний хэлбэлзэлтэй байгааг түүвэрлэлтийн алдаа илэрхийлнэ. Түүврийн загвар болон түүврийн хэмжээнд тулгуурлан алдааг тооцсон бөгөөд зарим нэг үзүүлэлтийн алдааны хязгаар өндөр байх нь түүврийн загварыг сонгох үе шатанд харагдаж байсан.

Судалгааны түүвэрлэлтийн алдааг дараах үзүүлэлтийн тусlamжтайгаар тооцоолсон бөгөөд түүврийн алдааг илэрхийлэх гол үзүүлэлт нь вариацийн коэффициент болно.

- Ерөнхий олонлогийн үзүүлэлтийн тооцооны утга
- Стандарт алдаа
- Вариацийн коэффициент
- 95 хувийн итгэмжлэгдэх интервал
- Тооцоо хийхэд ашиглагдсан ажиглалтын тоо

Түүвэрлэлтийн алдааг судалгааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд улсын түвшин, хот, хөдөө, хүйсээр, бус нутаг, аймгийн хэмжээнд гэсэн ангиллаар тооцсон.

Нийт хүн ам

	Тоошооны утга	Ажиглал- тын тоо	Дунджаас хазайх хазайлт	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент (стандарт алдаа)
				Доод	Дээд	
НИЙТ ХОТ, ХӨДӨӨ	2,600,597	47,493	274.3	2,600,049	2,601,146	0.6
Хот	1,544,319	28,888	307.2	1,543,705	1,544,934	1.1
Хөдөө	1,056,278	18,605	267.4	1,055,743	1,056,813	1.4
ХҮЙС						
Эрэгтэй	1,277,786	23,321	161.4	1,277,463	1,278,108	0.7
Эмэгтэй	1,322,812	24,172	165.0	1,322,482	1,323,142	0.7
БҮС						
Баруун	397,176	7,882	113.7	396,949	397,404	1.4
Хангай	546,653	9,350	117.5	546,418	546,888	1.3
Төв	443,001	7,338	100.9	442,799	443,202	1.4
Зүүн	209,192	3,589	78.7	209,035	209,350	2.2
Улаанбаатар	1,004,575	19,334	163.0	1,004,249	1,004,901	0.8
АЙМАГ						
Архангай	85,557	1,468	40.9	85,476	85,639	2.8
Баян-Өлгий	92,516	1,896	55.7	92,404	92,627	2.9
Баянхонгор	84,532	1,639	59.2	84,414	84,651	3.6
Булган	63,808	1,086	32.4	63,743	63,873	3.0
Говь-Алтай	58,546	1,086	31.6	58,483	58,609	2.9
Дорноговь	57,613	1,007	43.3	57,527	57,700	4.3
Дорнод	77,084	1,429	49.9	76,984	77,184	3.5
Дундговь	49,104	898	40.2	49,023	49,184	4.5
Завхан	88,042	1,660	53.4	87,935	88,149	3.2
Өвөрхангай	106,504	1,606	51.9	106,400	106,607	3.2
Өмнөговь	55,579	882	30.1	55,519	55,639	3.4
Сүхбаатар	58,808	1,128	49.3	58,709	58,906	4.4
Сэлэнгэ	94,823	1,471	47.3	94,728	94,917	3.2
Төв	81,117	1,268	46.9	81,023	81,211	3.7
Үвс	80,593	1,554	45.7	80,501	80,684	2.9
Ховд	77,480	1,686	54.1	77,372	77,588	3.2
Хөвсгөл	119,815	2,016	51.1	119,713	119,917	2.5
Хэнтий	73,300	1,032	34.9	73,231	73,370	3.4
Дархан-Үул	90,360	1,472	31.8	90,297	90,424	2.2
Улаанбаатар	1,004,575	19,334	163.0	1,004,249	1,004,901	0.8
Орхон	86,437	1,535	41.5	86,354	86,520	2.7
Говьсүмбэр	14,405	340	12.7	14,380	14,430	3.7

Ажиллах хүч

	Тоошооны утга	Ажиглалтын тоо	Дунджаас хазайх хазайлт	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент (стандарт алдаа)
				Доод	Дээл	
НИЙТ ХОТ, ХӨДӨӨ	1,147,144	20,869	182.1	1,146,780	1,147,508	0.9
Хот	619,109	11,568	137.8	618,833	619,384	1.2
Хөдөө	528,035	9,301	145.0	527,745	528,325	1.6
ХҮЙС						
Эрэгтэй	606,842	11,028	108.5	606,625	607,059	1.0
Эмэгтэй	540,301	9,841	100.3	540,101	540,502	1.0
БҮС						
Баруун	187,935	3,731	63.3	187,809	188,062	1.7
Хангай	268,276	4,574	92.3	268,091	268,460	2.0
Төв	215 ба 421	3,558	61.7	215 ба 297	215 ба 544	1.7
Зүүн	80,364	1,407	71.7	80,220	80,507	5.1
Улаанбаатар	395,148	7,599	85.3	394,978	395,319	1.1
АЙМАГ						
Архангай	49,414	849	28.6	49,357	49,472	3.4
Баян-Өлгий	43,346	891	28.9	43,289	43,404	3.2
Баянхонгор	37,649	728	38.5	37,572	37,726	5.3
Булган	30,717	523	20.4	30,676	30,757	3.9
Говь-Алтай	30,986	573	18.3	30,950	31,023	3.2
Дорнговь	29,207	512	24.2	29,159	29,256	4.7
Дорнод	26,211	484	36.0	26,139	26,283	7.4
Дундговь	24,243	443	22.9	24,197	24,288	5.2
Завхан	38,977	734	36.7	38,904	39,051	5.0
Өвөрхангай	54,354	820	52.4	54,249	54,459	6.4
Өмнөговь	27,677	438	15.8	27,645	27,709	3.6
Сүхбаатар	30,470	587	37.3	30,395	30,544	6.4
Сэлэнгэ	47,121	732	25.8	47,069	47,173	3.5
Төв	42,406	661	30.3	42,345	42,467	4.6
Үвс	38,700	749	20.4	38,659	38,741	2.7
Ховд	35,925	784	31.6	35,862	35,989	4.0
Хөвсгөл	58,402	983	41.8	58,318	58,486	4.3
Хэнтий	23,683	336	30.4	23,622	23,744	9.0
Дархан-Үул	38,983	635	19.6	38,944	39,022	3.1
Улаанбаатар	395,148	7,599	85.3	394,978	395,319	1.1
Орхон	37,739	671	31.9	37,675	37,803	4.8
Говьсүмбэр	5,784	137	11.0	5,762	5,806	8.0

Ажиллагчид

	Тоошооны утга	Ажиглалтын тоо	Дунджаас хазайх хазайлт	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент (стандарт алдаа)
				Доод	Дээд	
НИЙТ ХОТ, ХӨДӨӨ	1,033,708	18,771	190.4	1,033,327	1,034,088	1.0
Хот	547,060	10207	131.2	546,797	547,322	1.3
Хөдөө	486,648	8564	148.8	486,350	486,946	1.7
ХҮЙС						
Эрэгтэй	543,103	9848	113.1	542,877	543,329	1.1
Эмэгтэй	490,605	8,923	101.3	490,402	490,807	1.1
БҮС						
Баруун	169,022	3,360	70.8	168,881	169,164	2.1
Хангай	236,402	4028	108.0	236,186	236,618	2.7
Төв	195,444	3219	65.7	195,312	195,575	2.0
Зүүн	71,956	1,252	69.7	71,817	72,096	5.6
Улаанбаатар	360,884	6,912	84.6	360,714	361,053	1.2
АЙМАГ						
Архангай	45,956	789	32.6	45,891	46,021	4.1
Баян-Өлгий	42,116	865	29.9	42,056	42,176	3.5
Баянхонгор	36,298	703	38.3	36,221	36,374	5.4
Булган	26,055	441	26.7	26,001	26,108	6.0
Говь-Алтай	28,183	519	23.5	28,136	28,230	4.5
Дорноговь	24,599	433	26.6	24,546	24,653	6.1
Дорнод	22,990	423	36.4	22,917	23,063	8.6
Дундговь	21,786	399	24.5	21,737	21,835	6.1
Завхан	33,194	626	37.9	33,118	33,270	6.1
Өвөрхангай	51,715	780	54.9	51,605	51,825	7.0
Өмнөговь	23,408	370	16.3	23,376	23,441	4.4
Сүхбаатар	26,273	508	42.6	26,188	26,358	8.4
Сэлэнгэ	46,139	716	26.6	46,086	46,192	3.7
Төв	39,865	622	32.3	39,800	39,930	5.2
Үвс	32,913	638	19.9	32,873	32,953	3.1
Ховд	32,617	712	36.7	32,544	32,691	5.2
Хөвсгөл	48,429	816	53.0	48,323	48,535	6.5
Хэнтий	22,693	321	27.8	22,637	22,749	8.7
Дархан-Уул	34,691	562	21.5	34,648	34,734	3.8
Улаанбаатар	360,884	6,912	84.6	360,714	361,053	1.2
Орхон	27,950	499	38.2	27,874	28,027	7.7
Говьсүмбэр	4,954	117	10.5	4,933	4,975	9.0

Ажилгүй иргэд

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Дунджаас хазайх хазайлт	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент (стандарт алдаа)
				Доод	Дээд	
НИЙТ ХОТ, ХӨДӨӨ	113,436	2,098	58.0	113,320	113552	2.8
Хот	72,049	1361	46.3	71,957	72142	3.4
Хөдөө	41,387	737	42.0	41,303	41471	5.7
ХҮЙС						
Эрэгтэй	63,739	1180	36.7	63,666	63813	3.1
Эмэгтэй	49,697	918	25.8	49,645	49748	2.8
БҮС						
Баруун	18,913	371	26.2	18,861	18966	7.1
Хангай	31,874	546	35.8	31,802	31945	6.6
Төв	19,977	339	22.0	19,933	20021	6.5
Зүүн	8,408	155	18.2	8,371	8444	11.7
Улаанбаатар	34,265	687	32.1	34,200	34329	4.7
АЙМАГ						
Архангай	3,459	60	10.2	3,438	3,479	16.9
Баян-Өлгий	1,231	26	3.6	1,224	1,238	13.9
Баянхонгор	1,352	25	4.9	1,342	1,362	19.7
Булган	4,662	82	14.9	4,632	4,692	18.2
Говь-Алтай	2,804	54	10.7	2,782	2,825	19.8
Дорноговь	4,608	79	9.4	4,589	4,627	11.9
Дорнод	3,221	61	12.3	3,197	3,246	20.2
Дундговь	2,456	44	7.5	2,441	2,471	17.1
Завхан	5,783	108	15.8	5,752	5,815	14.6
Өвөрхангай	2,639	40	6.7	2,626	2,652	16.7
Өмнөговь	4,269	68	10.6	4,248	4,290	15.6
Сүхбаатар	4,197	79	11.3	4,174	4,219	14.4
Сэлэнгэ	982	16	3.1	976	988	19.1
Төв	2,541	39	6.5	2,528	2,554	16.7
Үвс	5,787	111	12.7	5,762	5,812	11.4
Ховд	3,308	72	10.6	3,287	3,329	14.7
Хөвсгөл	9,973	167	22.6	9,928	10,019	13.5
Хэнтий	990	15	7.0	976	1,004	46.7
Дархан-Үул	4,291	73	10.5	4,270	4,312	14.4
Улаанбаатар	34,265	687	32.1	34,200	34,329	4.7
Орхон	9,789	172	15.7	9,757	9,820	9.2
Говьсүмбэр	830	20	4.0	822	838	20.0



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Хаяг: Засгийн газрын III байр, Улаанбаатар- 20 а, Монгол Улс

Утас: 322424, 326414, 261523, Факс: (976 -11) - 324518

Цахим хаяг: nso@magicnet.mn, information@nso.mn

Веб хаяг: <http://www.nso.mn>